

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 03 дугаар сарын 28-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-15
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	16-38
1.“Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, үндсэн болон гүйлгээний сангийн зарлагын 2023 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монголбанк 2022.12.30-ны өдөр ирүүлсэн, хэлэлцэх эсэх/	17-20
2.“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /“Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий/	20-21
3.Төмөр замын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	21-38

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 03 дугаар сарын 28-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 24 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Батлут, Н.Ганибал, Ч.Хүрэлбаатар;

Чөлөөтэй: Т.Аюурсайхан, Д.Бат-Эрдэнэ, Б.Жавхлан, М.Оюунчимэг, Б.Энхбаяр.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, С.Чинзориг нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг хариулж, тайлбар хийв.

Нэг. “Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, үндсэн болон гүйлгээний сангийн зарлагын 2023 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монголбанк 2022.12.30-ны өдөр ирүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Монголбанкны Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал А.Энхжин, Эрдэнэсийн сангийн хэлтсийн захирал П.Эрдэнэтуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван төслийн талаар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Цэрэнпунцаг: “Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, үндсэн болон гүйлгээний сангийн зарлагын 2023 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 5

Бүгд: 10

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Цэрэнпунцаг: Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Цэрэнпунцаг: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /“Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг тогтоолын төслийн талаар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Цэрэнпунцаг: “Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 7
Бүгд: 11
36.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Цэрэнпунцаг: Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Ц.Цэрэнпунцаг: Горимын санал дэмжигдсэн тул дээрх батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

“Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Н.Ганибал, Д.Батлут, Б.Энхбаяр нар ажиллахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Төмөр замын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа, Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Энхболд, ахлах шинжээч Л.Булганхүү, мөн газрын Далай ашиглалт, усан замын тээврийн хэлтсийн дарга Д.Жавхлан, Төмөр замын тээврийн хэлтсийн дарга Х.Итгэлт, шинжээч Ц.Наранчимэг, Б.Хулан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн саналыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн тавьсан асуултад Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Төмөр замын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Цэрэнпунцаг: Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, А.Адьяасүрэн, Б.Баттөмөр, Э.Бат-Амгалан, Б.Жавхлан, М.Оюунчимэг, С.Чинзориг /Цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, 1. Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “бусад байгууламж” гэсний өмнө “салбар зам,” гэж нэмэн, 4.1.9 дэх заалтын “зам талбай, хүлээн авах, олгох, хадгалах үйлчилгээ үзүүлэх,” гэснийг “хадгалах зам талбай” гэж, 4.1.24 дэх заалтын “аюулгүй байдлыг хангах хатуу бүртгэл, дугаар, хяналттай ашиглах” гэснийг “аюулгүй байдлыг хангахад ашиглах” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Татгалзсан: 6
Бүгд: 11
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Чинзоригийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Цэрэнпунцаг: Улсын Их Хурлын гишүүн С.Чинзоригийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Цэрэнпунцаг: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Ц.Цэрэнпунцаг: 2. Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.2 дахь заалтын “технологийн” гэснийг болон 4.1.11 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалт болон 7.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтын “14.1.2-14.1.6-д” гэснийг “14.1.1-14.1.4-д” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтын “ашиглах зөвшөөрлийг” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.27 дахь заалтын “төмөр замын тээвэр зуучлалын” гэснийг хасаж, 11.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.2.Энэ хуулийн 11.1.1, 11.1.2, 11.1.3-т заасан дүрэм, 11.1.4, 11.1.5, 11.1.7, 11.1.8, 11.1.9, 11.1.12, 11.1.14, 11.1.17, 11.1.25, 11.1.27-д заасан журам, 11.1.20-д заасан аргачлал, 11.1.21-д заасан нормыг төмөр замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, энэ хуулийн 11.1.6, 11.1.10, 11.1.11, 11.1.13, 11.1.16, 11.1.18, 11.1.19-т заасан журмыг төрийн захиргааны байгууллага тус тус батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Төслийн 13 дугаар зүйлийн 13.2.1 дэх заалтын “засварлах, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийн ажлын” гэснийг “өргөтгөх, шинэчлэх, зураг төсөл боловсруулах ажлын” гэж өөрчлөн, 13.3 дахь хэсгийн “зохион байгуулна” гэсний өмнө “энэ хуулийн 11.1.25-д заасан журмын дагуу” гэж нэмэн, 13.2.3 дахь заалтын “, тусламж” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 5
Бүгд: 10
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Чинзоригийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Цэрэнпунцаг: Улсын Их Хурлын гишүүн С.Чинзоригийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Цэрэнпунцаг: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

8.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1.5, 14.1.6 дахь заалт, 14.4 дэх хэсэг болон 14.3 дахь хэсгийн “, 5.12, 5.13” гэснийг тус тус хасаж, 14.1.1 дэх заалтын “суурь бүтэц барих” гэсний дараа “, зураг төсөл боловсруулах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “тусгай зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүний нөөцийн болон техникийн чадвар, чадвартай эсэх, төмөр замын объект, үйл ажиллагаанд тавигдах” гэснийг “энэ хуулийн 14.3-т заасан” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Төслийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “газар нь төмөр замын зурвас газарт хамаарна” гэснийг “газрыг төмөр замын зурвас газар гэнэ” гэж өөрчлөн, мөн хэсгийн “шугамын” гэснийг болон 17.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Төслийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “газар нь төмөр замын хамгаалалтын бүсэд хамаарна” гэснийг “хэсэгчилсэн хамгаалалтын бүстэй байж болно.” гэж өөрчлөн, 18.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцагийн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Төслийн 23 дугаар зүйлийн 23.3.1, 23.3.2 дахь хэсгийн дугаарлалтыг сольж, 23.3.2 дахь хэсгийн “тухайн төмөр замын суурь бүтэц” гэснийг, 23.4.10 дахь заалтын “эрх бүхий байгууллагын гүйцэтгэсэн” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Төслийн 26 дугаар зүйлийн 26.1.2 дахь заалтыг “суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгчид галт тэрэг харилцан чөлөөтэй нэвтрэх нөхцөлийг тусгасан гэрээ байгуулсан байх;” гэж, 26.1.3 дахь заалтыг “суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч болон тээвэрлэгч нь энэ хуулийн 25.1-д заасан үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан гэрээ байгуулсан байх;” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 3

Бүгд: 10

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Төслийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийн “өмчлөгч” гэсний дараа “, эзэмшигч нь” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 3

Бүгд: 10

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Төслийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийн “байх зарчим баримтална” гэснийг “байна” гэж өөрчлөн, 31.2 дахь хэсгийн “бусад дэд бүтэцтэй” гэсний өмнө “энэ хуулийн 31.1-д зааснаас” гэж нэмэн, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 31.4 дэх хэсэг болон Тайлбар тус тус нэмэх:

“31.4.Төмөр замын суурь бүтэцтэй огтлолцох авто зам болон бусад төрлийн суурь бүтцийн зураг төслийг боловсруулахдаа төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөнө.

Тайлбар: Энэ хуулийн 31.1-д заасан “бусад төрлийн суурь бүтэц” гэж метро, трамвай, соронзон болон тусгай загвар бүхий түүнтэй адилтгах нийтийн тээврийн төмөр замыг ойлгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 3

Бүгд: 10

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Төслийн 32 дугаар зүйлийн нэрийн “зам” гэснийг “замын үйлчилгээ” гэж, 32.2 дахь хэсгийн “замтай” гэснийг “замын үйлчилгээтэй” гэж, 32.3 дахь хэсгийн “замын холболтын цэгийг” гэснийг “замыг холбох, өргөтгөх, салаалахтай холбоотой асуудлыг суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгчийн саналыг харгалзан” гэж тус тус өөрчлөн, 32.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Салбар замын үйлчилгээнд ачаа ачих, буулгах, сэлгээний ажил хийх, ачаа хүлээн авах, олгох, хадгалах, шилжүүлэх зэрэг үйл ажиллагаа хамаарна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 3

Бүгд: 10

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Төслийн 39 дүгээр зүйлийн нэрийн “бүрэлдэхүүнд тавигдах” гэснийг “бүрэлдэхүүн, түүний эд ангийг үйлдвэрлэх, угсрах, засварлахад тавих” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 4

Бүгд: 10

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Төслийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсгийн “газраар” гэсний дараа “хүн, техник хэрэгсэл” гэж нэмэн, 43.5 дахь хэсгийн “тээвэрт тусгай зориулалтын багаж, хэрэгсэл ашиглах” гэснийг “тээвэрт ашиглах тусгай зориулалтын багаж хэрэгсэл нь бүртгэл, дугаар, хяналттай байх бөгөөд түүнийг ашиглах” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 3

Бүгд: 10

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Төслийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсгийн “тээврийн байгууллага” гэснийг “суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч, тээвэрлэгч, салбар зам эзэмшигч” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 4

Бүгд: 10

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Төслийн 44 дүгээр зүйлийн 44.4 дэх хэсгийн “зорчигч болон ачаа тээврийн тарифыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд албан ёсоор мэдээлэхгүйгээр” гэснийг “тээврийн тарифыг цахим хуудас, мэдээллийн самбар, мэдээллийн бусад хэрэгслээр олон нийтэд албан ёсоор мэдээлэхгүйгээр” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 3

Бүгд: 10

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Төслийн 44 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 44.5-44.7 дахь хэсэг нэмэх:

“44.5.Төрийн захиргааны байгууллагын дэргэд төмөр замын тээврийн тарифыг оновчтой тогтоох асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий төмөр замын тээврийн тарифын орон тооны бус зөвлөл ажиллах бөгөөд дүрмийг нь төмөр замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

44.6.Энэ хуулийн 44.5-д заасан зөвлөлийн дарга, гишүүнийг төмөр замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн төрийн захиргааны байгууллагын дарга томилж, чөлөөлөх ба нарийн бичгийн дарга нь орон тооны байна.

44.7.Зөвлөл нь эдийн засаг, хөгжлийн, төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын болон Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын төлөөллөөс гадна ашгийн ба ашгийн бус хуулийн этгээдийн төлөөллийг оролцуулсан таван хүний бүрэлдэхүүнтэй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Ц.Цэрэнпунцаг нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Төслийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсгийн “2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс” гэснийг “2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 5
Бүгд: 10
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Цэрэнпунцаг: Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Цэрэнпунцаг: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Төслийн 26 дугаар зүйлийн 26.1.4 дэх заалтын дугаарыг “26.6” гэж, 47 дугаар зүйлийн 47.1.2 дахь заалтын дугаарыг “47.2” гэж, 47.1 дэх хэсэг, 47.1.1 дэх заалтын дугаарыг нэгтгэн “47.1” гэж, мөн төсөлд зүйл, хэсэг, заалт хасах, нэмэх саналтай уялдуулан төслийн нэр томъёог жигдлэх, холбогдох зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

эшлэлийг нийцүүлэн өөрчлөх засварыг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Төслийн 10 дугаар зүйлд тусгагдсан зохицуулалтыг төслийн үзэл баримтлалд тусгагдсаны дагуу дэмжсэнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасныг үндэслэн “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тогтоолын төслийг боловсруулж, хэлэлцүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн гаргасан, 1.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.7 дахь заалтын “осол” гэсний, 11.1.17 дахь заалтын “салбарын” гэсний, 4 дүгээр зүйлийн 4.1.21 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, 27 дугаар зүйлийн 27.2.6 дахь заалт, 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийн “аюулгүй байдал” гэсний, 42.2 дахь хэсгийн “дүрэм” гэсний өмнө болон 12 дугаар зүйлийн гарчгийн “Төмөр замын” гэсний дараа “тээврийн” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1.18 дахь заалт, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийн “ажилтан” гэсний, 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсгийн “ажилтанг” гэсний өмнө “тээврийн байгууллагын” гэж, 34 дүгээр зүйлийн 34.4 дэх хэсгийн “сэргийлэх” гэсний өмнө “урьдчилан” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.19 дэх заалтын “баримт бичгийг” гэснийг “хуваарийг” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалтын “газар олгох, чөлөөлөх” гэснийг “газар эзэмшүүлэх эрх олгох, газар чөлөөлөх” гэж, 10 дугаар зүйлийн гарчиг, 10.1 дэх хэсэг, 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсгийн “эрхэлсэн” гэснийг “хариуцсан” гэж, 10 дугаар зүйлийн 10.2.9, 11 дүгээр зүйлийн 11.1.17 дахь заалтын “ажилтан бэлтгэх, давтан сургах” гэснийг “ажилтан сургах, давтан сургах, мэргэшүүлэх” гэж, 10.2.11 дэх заалтын “ажиллагаанд” гэснийг “ажилд” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1.10 дахь заалтын “огтлолцох” гэснийг “нэвтрэх” гэж, 11.1.25 дахь заалтын “техник, технологийн” гэснийг “техникийн” гэж, “хөрөнгийг” гэснийг “эх үүсвэрийг бүрдүүлэх” гэж, 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн “тээврийн аюулгүй байдлыг хангахад зориулагдсан” гэснийг “тээвэрт ашиглагдах” гэж, 14 дүгээр зүйлийн 14.1.3 дахь заалтын “түүний эд ангийг” гэснийг “тэдгээрийн эд анги” гэж, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “бүсэд хамааруулна” гэснийг “бүс гэнэ” гэж, 16.2 дахь хэсгийн “журмаар тогтоосон дэглэмээс бусад үйл ажиллагаа явуулах, нэвтрэх, объект байрлуулахыг” гэснийг “журамд тусгагдсанаас бусад үйл ажиллагаа явуулахыг” гэж, 24

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийн “замыг” гэснийг “замын суурь бүтцийг” гэж, 34 дүгээр зүйлийн 34.8 дахь хэсгийн “журамд” гэснийг “журам, зааварт” гэж, 36 дугаар зүйлийн 36.4 дэх хэсгийн “тээшийг олгох үед” гэснийг “тээшинд” гэж, 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийн “техник хэрэгслийн бэлэн байдлыг хангаж, материалын нөөцийг бүрдүүлсэн” гэснийг “техник хэрэгсэл, материалын нөөцийн бэлэн байдлыг хангасан” гэж, 42.6.3 дахь заалтын “ачааг” гэснийг “ачаа, тээш, ачаан тээшийг” гэж, 44 дүгээр зүйлийн 44.3 дахь хэсгийн “Тарифын” гэснийг “Тээврийн тарифын” гэж, “хүчин төгөлдөр болохоос” гэснийг “мөрдөж эхлэхээс” гэж, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийн “дүрэмт” гэснийг “албаны” гэж, 47.1.1 дэх заалтын “олгох;” гэснийг “олгоно.” гэж, 47.1.2 дахь заалтын “тэтгэмж” гэснийг “тусламж” гэж, “зохицуулах;” гэснийг “зохицуулна.” гэж, “дотоод” гэснийг “хөдөлмөрийн дотоод” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 5
Бүгд: 10
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Цэрэнпунцаг: Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Цэрэнпунцаг: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн ТАВДУГААР БҮЛЭГ-ийн нэрийн “ТЭЭВРИЙН” гэснийг, 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсгийн “төмөр замын суурь бүтцийн” гэснийг, 23 дугаар зүйлийн 23.3.3, 23.4.1, 23.4.5, 23.4.6, 23.4.7, 23.4.9 дэх заалтын “төмөр замын” гэснийг, 40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсгийн “ашиглаагүй үед” гэснийг, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийн “байгууллагын ажилтан дараах нийгмийн баталгаагаар хангагдана:” гэснийг, 47.1.1 дэх заалтын “төмөр замын тээврийн” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Төмөр замын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Цэрэнпунцаг: Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.4-ийн дараа, 14.5.энэ хуулийн 14.1.2, 14.1.3, 14.1.4-т заасан тусгай зөвшөөрлийг нэг хуулийн этгээдэд давхардуулан олгохыг хориглоно гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дуусав.

Төмөр замын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн гаргасан, 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 14.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “алдагдсан үйл явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг аваагүй буюу зохих ёсоор аваагүй, мэдээлээгүй, ангиллыг буруу тогтоосон, сэргээн босгох, шинжлэн шалгах үйл ажиллагаанд” гэснийг “алдагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй, осол, зөрчлийг шинжлэн шалгахад болон төмөр замын суурь бүтцийг сэргээн босгох үйл ажиллагаанд” гэж, 2 дахь хэсгийн “талаарх олон улсын гэрээг” гэснийг “дүрэм, журмыг” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 14.10 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.1 дэх заалтын “ердийн хөсөг, тээврийн хэрэгслийг” гэснийг “ердийн хөсгийг” гэж, 4 дэх хэсгийн “Хуулиар хориглосон” гэснийг “Шаардлага хангаагүй” гэж, “хэрэгсэл, технологийг” гэснийг “хэрэгслийг” гэж тус тус өөрчлөн, 3 дахь хэсгийн 3.2 дахь заалтын “байгууламж барьсан,” гэсний дараа “объект байрлуулсан,” гэж, 5 дахь хэсгийн “Суурь бүтцийн” гэсний өмнө “Төмөр замын” гэж, “эзэмшигч нь” гэсний өмнө “өмчлөгч,” гэж, “саад” гэсний өмнө “үндэслэлгүйгээр” гэж, мөн хэсгийн болон 6 дахь хэсгийн “мянган” гэсний өмнө “нэг” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 14.10 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн “ажиллагаа эрхлэхдээ” гэснийг “ажиллагааг” гэж, 7.3 дахь заалтын “шилжүүлсэн” гэснийг “шилжүүлж” гэж тус тус өөрчлөн, мөн хэсэгт “7.4.бусдын тусгай зөвшөөрлөөр эрхэлсэн” гэсэн агуулгатай заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Төмөр замын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн гаргасан, 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 29.1.12 дахь заалтын “техник, эдийн засгийн үндэслэл,” гэснийг хасаж, мөн зүйлийн “дараах” гэснийг “29.1.12 дахь” гэж, 29.1.12 дахь заалтын “тус тус” гэснийг “зөвшөөрөл тус бүрд” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “дараах” гэснийг “29.1.1, 29.1.2, 29.1.3 дахь” гэж, мөн зүйлийн 29.1.1, 29.1.2 дахь заалтын “тус тус” гэснийг “зөвшөөрөл тус бүрд” гэж, 29.1.2 дахь заалтын “түүний эд ангийг” гэснийг “гэдгээрийн эд анги” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмж, 3 дугаар зүйлийн дугаарыг “4” гэж өөрчлөх:

“3 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “29 дүгээр зүйл” гэснийг “29 дүгээр зүйлийн 29.1.4-29.1.11 дэх заалт” гэж өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцох талаар хэлэв.

Төмөр замын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн гаргасан, 1.Төслийн 1 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 6
Бүгд: 11
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Цэрэнпунцаг: Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Цэрэнпунцаг: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 3 дугаар зүйлийн дугаарыг “2” гэж өөрчлөх:

“1 дүгээр зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 5.1 дэх заалтын “Засгийн газар” гэснийг “Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, 5.7 дахь заалтын “тээвэрлэлтийн” гэснийг “тээвэрлэгчийн” гэж тус тус өөрчилсүгэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Төмөр замын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн гаргасан, 1.Төслийн 1 дүгээр зүйлийн “стандарт,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 4 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төсөлд доор дурдсан агуулгатай зүйл нэмэх:

“4 дүгээр зүйл.Төмөр замын тээврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ болон хамт баталсан Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар төмөр замын зураг төсөл боловсруулах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ, суурь бүтцийн болон хөдлөх бүрэлдэхүүний эд ангийг үйлдвэрлэх, угсрах, засварлах үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр хэрэгжүүлэхээр зохицуулсан зүйл, хэсэг, заалтыг Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу зөвшөөрлийг нэмэх, задлах, хуваах, салгах, түүний хамрах хүрээг өргөжүүлэх асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэсний дараа дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 39 минут үргэлжилж, 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр 13 цаг 03 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 03 дугаар сарын 28-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим
11 цаг 24 минут.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023
ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ
ЧУУЛГАНЫ ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙНГЫН ХОРООНЫ 03 ДУГААР
САРЫН 28-НЫ ӨДӨР /МЯГМАР
ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Ц.Цэрэнпунцаг: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Батлут гишүүн орон нутагт ажиллаж байгаа юм байна. Тэгээд бусад нь ирж байгаа юм байна.

Ингээд хурлын ирц шаардлага хангаж байгаа тул ингээд хуралдааныг эхэлье. Байнгын хорооны гишүүдийн олонх буюу энэ 52.6% нь хувьтай бүрэлдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал.

1. “Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого үндсэн болон гүйлгээний сангийн зардлын 2023 оны төсвийн тухай” УИХ-ын тогтоолын төсөл Монголбанкнаас 2022 оны 12 сарын 30-нд ирүүлсэн. Ажлын хэсгийг оруулж байгаарай.

2-т, “ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл. “Төрийн өмчөөс орон нутгийн өмчит эд хөрөнгө шилжүүлэх тухай”

УИХ-ын тогтоолын төслийг Байнгын хороо чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий.

3-д, Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд. 2023 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг хийгдэнэ.

Ингээд 3 асуудал байна. Хэлэлцэх асуудалтай холбоотой асуулт асуух гишүүд байна уу? Ганбаатар гишүүн, Чинзориг гишүүн. Ганбаатар гишүүний микрофоныг нээе.

Ж.Ганбаатар: Хэлэлцэх асуудалтай ч бас айхтар холбоотой биш. Гэхдээ хэлэхгүй болохгүй 1 зүйл байна. манай энэ БГД-ийн энэ нарны хорооллын замыг хорооллын дундах замыг нийтийн эзэмшлийн зам болгосон асуудал туршилтын хугацаандаа явж байгаа юм байна лээ. Тэгээд үүнийг сонгогдсон гишүүний хувьд энэ нэлээн буруу шийдвэр болжээ гэж үзэж байгаа юм. Үүнийгээ тэгээд туршилтын хугацаандаа явуулж үзээд өөрчлөх байлгүй гэж гишүүний хувьд харж байгаа. Хэн сонгогдсон 3 гишүүн Ганхуяг гишүүн, Одонтуяа гишүүн бид 3 ер нь хамтарсан маягаар энэ асуудлуудыг ер нь судалгааных нь явцад нь саналаа хүргүүлж байгаа. Тэгээд энэ Нарны гүүрнийхээ ачааллыг хорооллын дундах зам руу оруулчхаж байгаа юм. Энэ хорооллыг тэгээд бас хувийн хэвшил барьсан. Тэгээд тэр хувийн хэвшилтэй нь ярьж тохирдог ч юм уу, үгүй ч юм уу.

Тэгээд дээрээс нь энэ сургууль, цэцэрлэгтэй хороолол. Тэгээд сургууль цэцэрлэгийн хүүхдүүд нь яаж ирж, очих тэр тооцоолол, тэр сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн аюулгүй байдал, энэ асуудлыг яаж яасан юм бол. Тэгээд Нарны хорооллын юу гүүрний ачааллыг л багасгана гээд л Нарны хорооллынх нь тэр гүүрэн дээрээ түгжирч байхаар тэр хороолол дундаа түгжирнэ гэсэн 1 тиймэрхүү байдлаар асуудлыг ер нь

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

шийдвэрлэе гэсэн юм уу. Ер нь тэгэхдээ энэ шийдвэрүүд жоохон буруу байна. Тийм учраас энэ 3 асуудал байна. Ер нь тэгээд хороолол дундах замыг нийтийн эзэмшлийн зам болгож байгаа нь энэ. Тэгээд тэр Зайсангийнхаас чинь хамаагүй өөр асуудал л сонсогдоод байгаа юм л даа. Зайсангийнх бол угаасаа нийтийн эзэмшлийн талбайг л өөрчлөд л тойруулсан юм шиг байгаа юм. Тэгэхээр энэ Нарны хорооллын дундах хорооллын дундах замыг нийтийн эзэмшлийн болгосон энэ туршилтаар хийж байгаа асуудлыг бас харж үзэж энэ туршилтынхаа хугацаанд шийдвэрээ зөв болгож шийдвэр гаргасан хүмүүс нь буцаагаад зөв шийдвэр гаргана байх гэж итгэж байгаа. Тийм учраас сонгогдсон гишүүний хувьд Байнгын хороон дээрээ боломжоо ашиглаж өөрийнхөө юуг илэрхийлж байна гэдгийг бас хургээ ээ. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Чинзориг гишүүн асуултаа асууя. Чинзориг гишүүний микрофоныг нээе.

С.Чинзориг: Тойргоо тойрогтоо ярь. Тэр хэлэлцэх асуудлын 2 дахь асуудал дээр Их Хурлын тогтоолын төсөл орж ирсэн, тэгээд түүн дээр би заавал тэгж нэг ажлын хэсэг гаргах шаардлага байгаа юм уу гэж бодоод байх юм. Би ажлын хэсэг гаргах шаардлагагүй гэж л бодож байгаа. Наадах чинь дандаа нөгөө хэмнэлтийн хуулийн дагуу төсвийн болоод төрийн байгууллагуудад ашиглагдаж байсан үндсэн хөрөнгө, тэгээд баахан хуучин машинуудыг л энэ хууль, хяналтын байгууллагууд, Хил хамгаалах, Цагдаа нэг 50 орчим машиныг энэ эрүүл мэндийн байгууллагуудад олгоё энэ тэр гээд ЗГ энэ тэр яриад тэгээд хуваарь нь ТӨХ-той гараад нэлээд нь орон нутгууд руу нь шилжүүлчихсэн тийм асуудлууд байгаа юм шүү дээ дарга аа.

Тэгэхээр заавал түүн дээр 1 тийм ажлын хэсэг одоо гаргаад тэгээд ажиллаад байх тийм шаардлага хэрэгцээ

байгаа юм болов уу гэж би л бодоод байгаа юм.

Ц.Цэрэнпунцаг: Энэ Чинзориг гишүүн ээ, энэ ЗГ-аас энэ дээр тэр тогтоолын хавсралтад өөрчлөлт их орж байгаа гээд. Тэгээд энэ өөрчлөлт орж байгаа учраас нэлээн ажиллах хэрэгтэй байна гээд 1 ийм санал болгож байгаа учраас ажлын хэсэг гаргаж байж тэр өөрчлөлт дээрээ бас, тийм, түүн дээр та ер нь засаг дээрээ ажлын хэсэг чинь нэлээн сайн ажиллах хэрэгтэй байх тийм ээ. Харин тийм. Та нөгөө дээр 1 асуулт асуугаад байсан. Тэгээд өөрчлөлт оруулъя гэсэн юм уу, ер нь нэлээн өөрчлөлт оруулъя гэсэн юм гэнэ. Анхны орж ирсэн хавсралт байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр ажлын хэсэг гаргаж ажилласан нь дээр юм байна гээд ажлын хэсэг гаргаж байгаа юм шүү.

Өөр асуулт байна уу, гишүүдэд.

Гишүүд асуулт асууж дууслаа.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Хэлэлцэх асуудлын 1.

“Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого үндсэн болон гүйлгээний сангийн зарлагын 2023 оны төсвийн тухай” УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлъе.

Монголбанкнаас Эрдэнэсийн сангийн талаарх мэдээллээр маш нууцын тэмдэгтэй ирүүлсэн боловч Төрийн болон албаны нууцын тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-нд өөрчлөлт орж эрдэнэсийн сангийн асуудал төрийн нууцаас хасагдсан. Тийм учраас Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19-ийн 1-ийн 3-д заасныг үндэслэн энэ асуудлыг нээлттэй хэлэлцэнэ.

Эрдэнэсийн сангийн 2022 оны төсвийн гүйцэтгэл, 2023 оны төсвийн төслийн тухай танилцуулгыг

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Монголбанкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван танилцуулна. Ажлын хэсгийн 2 номерын микрофоныг нээе.

Сая ажлын хэсгийн 2 номерыг нээе гээд хэлсэн. Болохгүй байна уу. Энэ техникийн саатал гараад байгаа юм уу. Дахиад шинээр эхэлж байна.

Г.Энхтайван: Эдийн засгийн байнгын хорооны дарга, УИХ-ын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2, 3 дугаар заалтын дагуу Монгол Улсын эрдэнэсийн сангийн орлого үндсэн болон гүйлгээ сангийн зарлагын 2023 оны төсвийг УИХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр өргөн барьж байна.

2022 онд Монгол Улсын Эрдэнэсийн сан 22.9 тонн үнэт металл худалдан авч гадаад валютын улсын нөөцийг 878 сая америк доллароор нэмэгдүүллээ. Монголбанк нь Соёлын яамтай байгуулсан 2022 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 0522/458 тоот гэрээний дагуу Чингис Хаан музейд Эрдэнэсийн сангаас 37 дэсийн 199 ширхэг түүх соёлын хосгүй үнэт үзмэрүүдийг үзэсгэлэнд дэглэн хамтран ажиллаж байна.

УИХ-ын 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 9 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, үндсэн болон гүйлгээ сангийн зарлагын 2022 оны төсвийн гүйцэтгэл дараах байдалтай байна.

1. 2022 онд Монголбанк нь 2 тэрбум төгрөгөөр түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлс, байгалийн түрц худалдан авах, урлагийн бүтээл захиалан хийлгэх, археологийн олдворыг шилжүүлэн авах ажлыг хийхээр төсөвлөсөн бөгөөд 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар төсвийн гүйцэтгэл 954.5 сая төгрөг байна.

2. Монголбанк нь 200 ширхэг дурсгалын зоосны дээж үндсэн санд орлогдохоос 108 ширхгийг орлогдсон байна.

3. үндсэн сангийн байнгын бус хэсэгт Монголбанкны Мөнгөн тэмдэгтийн газраас шилжүүлэн авсан 165 ширхэг зоос болон мөнгөн тэмдэгтийг эрдэнэсийн сангийн тэнцлийн гадуурх данснаас шилжүүлэн бүртгэв.

Монгол Улсын УАБЗ-ийн 2022 оны 6 сарын 15-ны өдрийн 02 дугаар зөвлөмжийн 3.1-д Монголбанканд Чингис хааны алтадсан баримлын эх загварыг үндэсний түүх, соёл, өв уламжлал, зан заншилтай нийцүүлэн эх загварыг сайжруулан боловсруулж бүтээлгэн Чингис хааны музейн 9 дүгээр давхрын хүндэтгэлийн танхимын хамт цогцоор нь үзмэрийг дэглэн байршуулах тухай зөвлөмж өгсөн. Тус зөвлөмжийн хүрээнд Чингис хаан хүрэл баримал алтан тамга бүтээх ажлын холбогдох зардалд 4 тэрбум төгрөг төсөвлөсөн бөгөөд Чингис Хаан баримлын эх загварын эрх үйлдвэрлэл болон уран сайхны хяналт тавих, хүрэл баримлын үйлдвэрлэл, суурь чулууны ажилд нийтдээ 3.3 тэрбум төгрөгийг холбогдох гэрээний дагуу зарцуулаад байна.

Мөн 24392 ширхэг дурсгалын зоос болон алтан, мөнгөн гулдмай үрлэн мөнгө зарлагдахаар тусгаснаас 2022 онд нийт 1.4 тэрбум төгрөгийн өртөг бүхий 2973 ширхэг дурсгалын зоос, 234 ширхэг алт, мөнгөн гулдмай болон үрлийг нийт 2.3 тэрбум төгрөгөөр худалдсан байна.

2022 онд нийт зочин төлөөлөгчийн зардлаар 200 ширхэг дурсгалын зоос зарцуулахаар батлагдсанаас 169 ширхэг дурсгалын зоосыг зарцуулсан гүйцэтгэлтэй байна.

2023 оны Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, үндсэн болон

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

гүйлгээ сангийн зарлагын төсвийн төслийг та бүхэнд танилцуулъя.

Монголбанкнаас эрдэнэсийн сангийн сан хөмрөгийг 2023 онд дараах байдлаар баяжуулахаар төлөвлөж байна.

1. Эрдэнэсийн сангийн сан хөмрөгийг нэмэгдүүлэхэд түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлс, урлагийн бүтээл, байгалийн түрц алт худалдан авах мөн ШУА-ийн түүхийн хүрээлэн болон бусад байгууллагуудтай хамтран ажиллахад 2 тэрбум төгрөг, Чингис хаан Хүн музейн хүндэтгэлийн танхимд залах Чингис хаан хүрэл барималтай холбоотой зардалд нийт 8 тэрбум төгрөг төсөвлөж байна. Үүнд:

Чингис хаан баримлын хүрлийн үйлдвэрлэл, суурь чулууны зардал, баримлын болон хүндэтгэлийн танхимын интерьер, зураг төсөл, засварын зардал, дэглэлт, баримлын болон хүндэтгэлийн танхимын гэрэлтүүлэг, баримлын тээвэрлэлтийн зардал, гааль болон бусад татвар угсралт суурилуулалтын ажлыг багтаасан.

Мөн Чингис хаан баримлын 10:1 хэмжээтэй баримлыг бүтээлгэж, Эрдэнэсийн сан дэглэн олон нийтэд үзүүлэхээр төлөвлөж байна.

Эрдэнэсийн сангийн төсөвт тусгагдсан Чингис хааны хүрэл баримлыг бүрэх хааны тамга хийхэд зарцуулах алтны хэмжээг 150 килограммаар тооцоолсон.

2023 онд Эрдэнэсийн сангийн сан хөмрөгийг нэмэгдүүлэхээр дараах зүйлсийг орлогод бүртгэхээр төлөвлөж байна.

1. Чингис хаан баримлын үйлдвэрлэл, тээвэрлэлт, угсралт болон бусад ажлууд хийгдэж дууссаны дараа нийт өртгөөр нь Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн байнгын бус хэсэгт

Чингис хаан баримлыг хөрөнгөөр бүртгэнэ.

2. Монголбанкны санаачилгаар 10 төрөл байгууллагын хүсэлтээр 6 төрөл сэдвээр дурсгалын зоос үйлдвэрлүүлэхээр төлөвлөж буй бөгөөд нийт 200 ширхэг дээж зоосыг үндсэн сангийн байнгын бус хэсэгт орлогоор бүртгэнэ.

3. Гүйлгээ сангаас 23950 ширхэг дурсгалын зоос болон алтан, мөнгөн гулдмайн үрлэн мөнгө зарлагдахаар тусгаснаас худалдах зориулалттайгаар 23750 ширхгийг, зочин төлөөлөгчийн зардлаар 200 ширхэг дурсгалын зоос мөнгөн гулдмайд зарцуулахаар тусгалаа.

Эдийн засгийн байнгын хорооны дарга, УИХ-ын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, үндсэн болон гүйлгээ сангийн зарлагын 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, 23 оны төсвийн төслийг хэлэлцэж өгөхийг хүсье.

Ц.Цэрэнпунцаг: Энхтайван Ерөнхийлөгчид баярлалаа.

Ингээд ажлын хэсгийг танилцуулъя. Ажлын хэсэг Ганболдын Энхтайван Монголбанкны дэд ерөнхийлөгч, Атарбаатарын Энхжин Монголбанкны нөөцийн удирдлага санхүүгийн зах зээлийн газрын захирал, Пүрэвдоржийн Эрдэнэтуяа Эрдэнэсийн сангийн хэлтсийн захирал.

Танилцуулгатай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх УИХ-ын гишүүд нэрээ өгнө үү. Алга байна. Гишүүд асуулт гарсангүй тул санал хураалт явуулж эхэлье.

Санал хураалт. Гишүүд анхааралтай байгаарай. Суудалдаа суугаарай. Ганхуяг гишүүн ээ. Санал хураалт явуулж эхэлье.

Саналын томъёоллыг та бүхэндээ уншъя. Монгол УИХ-ын чуулганы нэгдсэн

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсгийг үндэслэн “Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, үндсэн болон гүйлгээний сангийн зарлагын 2023 оны төсвийн тухай” УИХ-ын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлуулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явууля.

Санал хураалт. Гишүүд ээ, анхааралтай байгаарай. Санал хураалт.

Энэ саяын саналын хураалтыг хүчингүй болгоодохё. Хүчингүй болгоё. Энэ Ганхуяг гишүүний төхөөрөмж ажиллахгүй байх шиг байна. Ганхуяг гишүүн санал гаргах уу. Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Саяын санал хураалтыг хүчингүй болгож өгнө үү. Миний төхөөрөмж гацчихлаа.

Ц.Цэрэнпунцаг: Ганхуяг гишүүний гаргасан саналаар саяын хураасан санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналын томъёоллоор санал хураалт явууля. Санал хураалт.

Гишүүдийн 54.5% нь дэмжиж, саяын санал хураалт хүчингүй боллоо.

Ингээд саяын санал хураалт хүчингүй болсон учраас дахин санал хураалт явууля. Санал хураалт. Гишүүд анхааралтай байгаарай.

Гишүүдийн 54.5% нь дэмжиж, санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа.

Тогтоолын төслийг хэлэлцсэн талаар Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд УИХ-ын гишүүн Ундрам гишүүн танилцуулна.

“Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, үндсэн болон гүйлгээний сангийн зарлагын 2023 оны төсвийн тухай” УИХ-ын тогтоолын

төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг дууслаа.

11.41 цаг

Ингээд дараагийн асуудалдаа орё.

Хэлэлцэх асуудал 2.

**“Ажлын хэсэг байгуулах тухай”
Байнгын хорооны тогтоолын төслийн
хэлэлцүүлгийг хийе.**

Ажлын хэсгийн бүрэлдэхүүний талаарх тогтоолын төслийг уншиж танилцууля. Ажлын хэсэг байгуулах тухай. Монгол УИХ-ын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь:

1. Монгол Улсын ЗГ-аас өргөн мэдүүлсэн “Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ч.Ундрам УИХ-ын гишүүн, гишүүд Х.Ганхуяг УИХ-ын гишүүн, Н.Ганибал УИХ-ын гишүүн, Д.Батлут УИХ-ын гишүүн, Б.Энхбаяр УИХ-ын гишүүн.

2. Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа авах чиглэлээр холбогдох яам, агентлаг, бусад байгууллагаас мэргэжилтэн, албан хаагчийг оролцуулж ажиллуулахыг ажлын хэсэг, ахлагч Ч.Ундрамд зөвшөөрсүгэй.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүний талаар саналтай гишүүд байна уу. Алга байна. Ингээд санал хураалт явууля.

“Ажлын хэсэг байгуулах тухай”
Байнгын хорооны тогтоолыг баталъя
гэсэн томъёоллоор санал хураалт явууля.
Санал хураалт.

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Энэ гишүүдийн төхөөрөмжүүд яачхаад байгаа юм. Булгантуяа гишүүн санал гаргах уу.

Х.Булгантуяа: Байнгын хорооны дарга аа, энэ төхөөрөмж ажиллахгүй. Ганбаатар гишүүн бид хоёрынх, санал нь эсрэг гараад болохгүй байна. Дарагдахаар дарагдахгүй байгаад байна. Дахин санал хураалт явуулж өгнө үү.

Ц.Цэрэнпунцаг: Булгантуяа гишүүн санал гаргалаа. Энэ саяын санал хураалтыг хүчингүй болгож дахин санал хураалт явуулж өгнө үү гэсэн. Тийм учраас саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Гишүүдийн 54.5% нь дэмжиж, саяын санал хураалт хүчингүй боллоо.

Ингээд дахин санал хураалт явуулъя. Гишүүд ээ, анхааралтай байгаарай. Санал хураалт. Санал хураалт.

Гишүүдийн 60 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа.

11.45 цаг

Ингээд дараагийнхаа асуулт оръё.

Хэлэлцэх асуудал 3, сүүлчийн асуудал.

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулна. Гишүүний микрофоныг нээнэ үү.

Бат-Эрдэнэ гишүүн та юугаа, суудлаа өөрчлөх юм уу. Микрофоноо сольж байна уу ажиллах уу? Тэгэхээр ажиллачихгүй шууд залгаад явуулчихдаг юм байна. Утасгүй юм байна. Та суудлаа сольсон нь дээр байх аа.

Ж.Бат-Эрдэнэ: Төмөр замын тээврийн тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулгыг та бүхэнд танилцуулъя.

Төмөр замын тээврийн тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг болон дэд ажлын хэсэг нийт 6 удаа хуралдсан. Ажлын хэсэг төслийг хэлэлцүүлэгт бэлтгэхдээ ажлын хэсгийн гишүүдийнхээ болон ажлын дэд хэсгээс бэлтгэсэн болон ди парламентаар хуулийн төсөлтэй холбогдуулан ирүүлсэн санал 1 бүрийг авч хэлэлцэж, шаардлагатай асуудлуудыг хуулийн төсөлд тусгах болон хуулийн төслийг бусад хууль тогтоомжтой нийлүүлэх, нэр томъёог жигдлэх зэргээр зөрөөтэй болон найруулгын шинжтэй саналуудыг бэлтгэн та бүхэнд хүргүүлсэн.

Ажлын хэсгийг дараах зарчмын өөрчлөлтийг хуулийн төсөлд тусган зохицуулах нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

1. Төмөр замын зурвас газар хамгаалалтын бүсийн газрын асуудлаарх төсөлд тусгагдсан зохицуулалтыг илүү сайжруулан тодорхой ойлгомжтой болгох,

2. Төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгчид хооронд болон суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч, тээвэрлэгч хооронд төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангаж ажиллах, тасралтгүй байх зарчмыг алдуулагдахгүй байхаар гэрээ байгуулан ажиллах зарчмыг тусгасан.

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Төмөр замын зураг төсөл боловсруулах техник, технологийн хяналт тавих, зөвлөх үйлчилгээг, түүнчлэн суурь бүтцийн болон хөдлөх бүрэлдэхүүний эд ангийг үйлдвэрлэх, угсрах, засварлах үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр хэрэгжүүлэхээр төсөлд тусгасан асуудлыг зарчмын хувьд дэмжиж, харин Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу холбогдох зөвшөөрлийг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэсний дараа дагаж мөрдөх нь зүйтэй. Харин төмөр замын салбарын үйл ажиллагаа дахь тусгай зөвшөөрлийг төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгох нь зүйтэй гэсэн ийм зарчмын асуудлуудыг тусгасан.

4-т, төмөр замын суурь бүтэцтэй I түвшин тогтолцох авто зам болон бусад төрлийн суурь бүтцийн зураг төслийг боловсруулахдаа төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөж шийдвэрлэх,

5. төмөр замаас салбарлах салбар замыг холбох, өргөтгөх, салаалахтай холбоотой асуудлыг суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгчийн саналыг харгалзах гэсэн саналыг оруулаа.

6. төмөр замын асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагын дэргэд төмөр замын тээврийн тарифыг оновчтой тогтоох асуудлаар дүгнэлт зөвлөмж гаргах үүрэг бүхий төмөр замын тарифын орон тооны бус зөвлөл ажиллах нь зүйтэй гэж үзсэн.

7. тээвэрлэгч нь тээврийн тарифыг цахим хуудас, мэдээллийн самбар, мэдээллийн бусад хэрэгслээр олон нийтэд албан ёсоор мэдээлэхгүйгээр мөрдөхийг хориглох,

8. хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх нь зүйтэй болно оо гэсэн ийм саналуудыг оруулаа. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ажлын хэсгээс бэлтгэсэн ажил саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын ажлын хэсгийг танилцуулъя.

Бямбацогт Зам, тээврийн хөгжлийн сайд, М.Энхболд ЗТХЯ-ны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын дарга, Д.Жавхлан ЗТХЯ-ны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын хэлтсийн дарга, Мяндасмаа ЗТХЯ-ны Хуулийн хэлтсийн дарга, Итгэлт ЗТХЯ-ны Төмөр зам, далайн тээврийн БХЗГ-ын Төмөр замын тээврийн хэлтсийн дарга, Булганхүү ЗТХЯ-ны Төмөр зам, далайн тээврийн БХЗГ-ын ахлах шинжээч Наранчимэг ЗТХЯ-ны Төмөр зам, далайн тээврийн БХЗГ-ын Төмөр замын тээврийн хэлтсийн шинжээч, ЗТХЯ-ны яамны Төмөр зам далайн тээврийн БХЗГ-ын Төмөр замын тээврийн хэлтсийн шинжээч.

Ажлын хэсгийн танилцуулгаас асуух асуулттай УИХ-ын гишүүд нэрээ өгнө үү. Ганхуяг гишүүнээр тасаллаа. Ганхуяг гишүүний микрофоныг нээе.

Х.Ганхуяг: Өчигдөр ч яах вэ, Бат-Эрдэнэ гишүүнтэй би ажлын хэсгийн даргатай уулзчихсан л даа. Тэгээд яах вэ, зөвшөөрлийн тоо эд нар нэмээгүй дээр талархаж байна. Гэхдээ энэ зарчмын асуудал үүсчхээд байгаа юм.

Зөвшөөрлийн хууль 2023 оны 01 сарын 01-нд дагаж мөрдөөд эхэлсэн. Зөвшөөрлийн хуулийн санаачлагч нь манай Бямбацогт сайд өөрөө байгаа. Тэгээд энэ зөвшөөрлийн хуулиар Ерөнхий сайдын дэргэд зөвлөл ажиллах юм. Төр, хувийн хэвшлийн хамтарсан зөвлөл. Тэгээд зөвшөөрлийг салгах, нийлүүлэх энэ зөвшөөрлийн хуульд ямар нэгэн өөрчлөлт орохоор бол тэр зөвлөлөөр хэлэлцэх, шаардлагатай нээлттэй сонсгол явуулах, судалгаа шинжилгээ хийх, тэгээд тэр зөвлөл нь тэр зөвлөлийн санал, дүгнэлтээр үндэслээд ЗГ тэр хууль нэмэлт, өөрчлөлт

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

оруулах эсэх, тэгээд ЗГ цаашаагаа Их Хурал руу өргөн барих асуудлыг шийдүүлэхээр хуульд туссан юм л даа. Тэгээд яах вэ, өнөөдөр ингээд Төмөр замын хууль гээд ороод ирчихсэн байгаа. Тэрнээс гадна дахиад 2 ч хууль УИХ-д өргөн баригдсан. Тэгээд яг энэ процессоо дагаагүй.

Тэгээд хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д хууль санаачлагч тодорхой хууль санаачлах бол холбогдох бусад хууль тогтоомжид заасан хүрээ, хязгаарт нийцүүлэн, хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлнэ гэж заасан байгаа. Тэгээд ингээд процессоо дагадаггүй, процесс гэдэг маань өөрөө шударга ёсны л асуудал шүү дээ. Тэгээд 1 ийм асуудал үүсчхээд байгаа юм. Тэгээд энэ дээр би УИХ-ын Тамгын газарт ч тэр, УИХ-ын даргад ч тэр, ЗГ-т ч тэр ингээд бичиг өнгөрсөн 7 хоногт хүргүүлчхээд, Их Хурлын Тамгын газар луу энэ 7 хоногт хүргүүлэх гээд байж байгаа. Хуулийг зөрчөөд хуулийн процессыг дагаад дагахгүйгээр ингээд асуудлууд яваад байгаа нь энэ жоохон зарчмын байр суурь дээр асуудал үүсээд байна л даа. Тэгээд би үүнийг хууль санаачлагчаас л асуудаг юм уу л гэж бодоод байна л даа.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсэг Бямбацогт сайд хариулах уу. Бямбацогт сайд гишүүн микрофоныг нээе.

С.Бямбацогт: Тийм ээ, Зөвшөөрлийн тухай хуулийг би санаачилсан. Тэгээд 1400 орчим зөвшөөрөл олгодог үүнээсээ болоод иргэд, ААН хүнд суртал учруулдаг, тэгээд гарын үсгээ үнэлдэг, энэ цаашаа шан харамж авлигал авах эх үүсвэр болсон үүнтэй холбоотой хамгийн их асуудал зөвшөөрөл дээр байна. Тусгай зөвшөөрөл олгох асуудалтай байна гэж энэ хуулийг сануулсан.

Энэ хуулийн мөрдөгдөөд явах юм бол нөгөө зөвшөөрөлтэйгөөс бусад нь тийм үү, чөлөөтэй байх. Урьд нь

зөвшөөрөлтэйгөөс бусад нь хориотой байсан. Энэ үзэл баримтлалын хүрээнд л явах ёстой. Тийм болохоор хүний эрүүл мэнд, амь нас, байгаль орчин, аюулгүй байдалд нөлөөлөхгүйц тийм үү, Үндэсний аюулгүй байдалд нөлөөлөхгүйц энэ асуудал дээр зөвшөөрөлгүй бусад бизнесүүдийг чөлөөтэй эрхлэх бололцоо боломжийг олгох ёстой гэдэг агуулгаар Зөвшөөрлийн тухай хуулийг санаачилсан. УИХ баталсан. УИХ. Одоо хамгийн гол нь хурдан хэрэгжих ёстой. Хэрэгжүүлэх асуудал дээр яах аргагүй Ганхуяг гишүүний ажлын хэсгийн ахлагч Ганхуяг гишүүн маань ажилласан. Маш сайн ажилласан. Ингээд зөвшөөрөл ЗГХЭГ-ын дэргэд Ерөнхий сайдын дэргэд энэ зөвшөөрлийн хуулийг зохицуулах зөвлөл ажиллах ёстой юм. Үүгээр зөвшөөрлийг нэмж олгох шаардлагатай юу, эс үгүй бол цөөлөх шаардлагатай юу? Зөвшөөрөл 1 бүрчлэн яриад энэ шаардлагагүй зөвшөөрөл байна, хүнд суртал гаргаж байна гэвэл хасах, байхгүй болгох. Зайлиггүй шаардлагатай тохиолдолд Үндэсний аюулгүй байдалтай холбоотой, хүний амь, нас эрүүл мэндтэй холбоотой асуудлууд, байгаль орчинтой холбоотой асуудлууд дээр зайлиггүй шаардлага зөвшөөрөл олгох ёстой болбол гарцаа байхгүй нэмэх ёстой юм байна гэсэн санал, дүгнэлтийг энэ байгууллага гаргаж байх ёстой юм.

Зөвшөөрлийн хууль маань 01 сарын 01-нээс хэрэгжээд эхэлчихсэн боловч өнөөдрийн байдлаар энэ зөвлөл маань байгуулагдаагүй байгаа юм. Зөвлөл байгуулагдаагүй байгаа учраас бид нар өнөөдөр зайлиггүй зөвшөөрлийг шийдэх шаардлага үүсээж байгаа учраас хуулийг оруулж ирсэн. Ингээд энэ хүрээнд хуулийг батлаад цаашаагаа явцдаа зөвлөл байгуулагдах юм бол бид бидний энэ төмөр замын тухай хуулиар олгогдох зөвшөөрлүүдийг нэн шаардлагатай мөн үү, биш үү гэдэг дээр дүгнэлтээ хийгээд шаардлагатай нэмж шинээр зөвшөөрөл олгох, шаардлагагүй хасах цөөлөх энэ асуудлыг шийднэ. Тийм болохоор тэр хүртэл хугацаанд бид нар Төмөр замын

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

тухай хуулиа батлахдаа энэ зөвшөөрлүүдийг нэг мөсөн хамтад нь шийдээд явж байя гэж байгаа. Ингэхгүй бол яах аргагүй төмөр зам тийм үү, бид нар олон төмөр замтай болчихсон. Энэ олон төмөр зам дээр олон хөдлөх бүрэлдэхүүн, олон компаниуд, хөдлөх бүрэлдэхүүн тээвэрлэлт хийж байгаа. Эдгээрийг зохицуулахгүй бол төмөр зам бол автомашин биш ээ. Төмөр зам дээгүүр 1 явахдаа хэдэн мянган тонн ачаа тээвэрлэдэг, төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн, төмөр зам барьж байгуулах хөрөнгө оруулалт хийхэд маш өндөр зардалтай өртөгтэй, маш өндөр, онц аюултай ачаа тээвэрлэдэг. Тийм учраас өндөр шаардлага тавина. Өндөр шаардлага тавихын тулд зөвшөөрөл зайлшгүй байх ёстой гэдэг агуулгаар орж ирсэн.

Ер нь бас ЗГ бас хууль тогтоомжийн хэрэгжилт нь тийм хуулиудын давхардал, хийдэл, тийм ээ. Энэ зөрчлийг хооронд нь арилгах асуудалд бас анхаарах ёстой, энэ ажлууд бас хийгдэх ёстой, энэ дээр ЗГХЭГ ажиллаж байгаа. Энэ Монгол Улс 400 гаруй хууль баталчихсан байж байгаа. Энэ батлагдсан хуулиудын хоорондынх нь давхардал, хийдэл, зөрчлүүдийг арилгаад саяын Зөвшөөрлийн хууль болон бидний Их Хурал дээр хэлэлцэж байгаа энэ хуулиудын зөрчлийг хэрхэн яаж арилгах вэ гэдэг дээр бас тодорхой шийдэл гарах ёстой юм аа. Энэ дээр ч гэсэн бас манай УИХ бас онцгой бас анхаарч ажиллах ёстой гэж үзэж байгаа. Тийм болохоор Төмөр замын тухай хуулиа батлаад явчихъя. Дараад нь ЗГ-ын Ерөнхий сайдын дэргэд тэр зөвшөөрлийг зохицуулах зөвлөл ажиллаад эхлэх юм бол тэндээ санал, дүгнэлтээ гаргаад асуудлыг шийдээд явчих бололцоотой гэж үзэж байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Ганхуяг гишүүний асуултад сайд хариуллаа. Ажлын хэсгийн ахлагч бас нэмж хариулах зүйл байвал нэмж хэлээрэй. 1-д.

Би бас яах вэ давхар бас 1 зүгээр ерөнхий 1 асуулт асууцихъя. Энд ЗТХЯ-ны сайд байна, энэ ЗТХЯ-ны сайд байсан Бат-Эрдэнэ гишүүн байна. Бат-Эрдэнэ гишүүн энэ эхэлж энэ хуулийн төсөл дээр ажиллаж байгаад буцаад татаж аваад тийм ээ, дахиад орж ирж байгаа. Би энэ зүгээр Байнгын хорооны гишүүддээ ерөнхий мэдээлэл өгөхөд. Тэгэхээр Бат-Эрдэнэ гишүүн та эхнийхээ хуулийн төсөл дээр ажиллаж байгаад татагдсан буцаад тийм ээ, дахиад орж ирж байгаа учраас ер нь энэ дээр энэ 2 орж ирсэн хууль буцаад татагдаад юу юу нь жигдрээд, ямар өөр онцлогтой орж ирж байгаа юм, агуулгын өөрчлөлт орсон юм уу яасан юм ерөнхийдөө бас гишүүддээ 1 тодорхой та мэдээлэл өгчхөөрэй. Ганхуяг гишүүний саяын асуулт дээр хариулаад нэмээд өгчхөөрэй.

Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг нээе.

Ж.Бат-Эрдэнэ: Тэгэхээр Төмөр замын тухай хууль маань орж ирээд шинэчилсэн саналаар орж ирсэн. Ажлын хэсэг нэлээд ажилласан. Урьд өмнө бид нар чинь төмөр зам үндсэндээ УБТЗ гээд ерөөсөө ганцхан төмөр замтай байлаа шүү дээ. Тэгээд үүний гол хуулийн үндэс нь ОХУ-ын хууль байгаа. Анх энэ төмөр зам маань ОХУ-ын тусламжаар баригдсан. Тэгээд хууль болон дотор барьж байдаг дүрэм журам бүх зүйлүүд ерөөсөө үндсэндээ Оросын холбооны дүрмээр ингээд явж байсан, 1 ААН-тэй байсан. Тэгэхээр бид өнөөдөр гэхэд олон ААН-тэй болчихлоо, маш олон тээвэрлэгчтэй болчихлоо. Надад ирсэн вагоноор юу, мэдээллээр жишээ нь 2, 3 компани байна. Мянган гаран, мянган гаран, мянган орчим вагонтой ийм компаниуд болчихоод байж байна. Тэгэхээр бид энэ тээврийнхээ төмөр замынхаа салбарыг либералчлах зайлшгүй шаардлагатай болчихож байгаа юм аа. Либералчлах. Тэгэхээр үүний хамгийн гол асуудал үндсэндээ тээврийн салбараа төмөр замын салбараа либералчлах, үүн дотроо доод суурь бүтэц энэ нь 1 эзэмшилтэй

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

байгаа. Тэр суурь бүтэц дээгүүр авто замаар ярих юм бол Монгол Улсын авто замын сүлжээ гэж бий болж байгаа. Энэ авто замын сүлжээ дээгүүр ямар л ямар машин дүрэм журмынхаа дагуу явж байх ёстой шүү дээ. Тэрэнтэй адилхан Монгол Улсын төмөр замын сүлжээ гэж бий болох, ингээд суурь бүтэц гэж тусдаа байх. Үүнийг эзэмшдэг хүмүүс нь ААН-үүд байна. Энэ дээгүүр тодорхой хэмжээний өртөгтэйгөөр, тодорхой хэмжээний төлбөртэйгөөр үйлчилгээ явуулж байдаг, ачаа тээвэр хийж байдаг, тээвэрлэгч компаниуд бий болох ёстой. Үндсэндээ УБТЗ гэж ганцхан компани байсан бол ингээд тээвэрлэгч энэ нүүрс, гал, нүүрстэй холбоотой асуудлууд, дээрээс нь транзит тээвэртэй холбоотой асуудлууд гээд маш олон ААН-үүд Монголын ААН-үүд, МТЗ гэж байж байна. Дээрээс нь хэд хэдэн компаниуд байж байна. Ийм ААН бий болгох ийм либералчилсан, шинэ нөхцөл байдалд зориулсан хууль болж орж ирж байгаа юм аа.

Тэгэхээр шинэчилсэн найруулга орж ирсэн, түүн дээр бас нэлээдгүй өөрчлөлтүүд орсон. Үг хэлний өөрчлөлтүүд, урьд өмнө бидний хэрэглээд олон жил хэрэглээд явсан УБТЗ дээр хэрэглээд байсан үг үсгээ нийтэд энэ чинь нийтийн хууль болж байна шүү дээ. Нийтэд эзэмших нийт даяараа Монголчууддаа зориулагдсан ийм либералчлагдсан ийм хууль болж байгаа. Тэгэхээр үг үсгээс авхуулаад шинэ хэлбэрээр хэрэглэгдэх, шинээр ойлгодог болох гэх мэтчилэн нэлээдгүй олон өөрчлөлтүүд орсон. Тэгээд ингээд тээврийн яам маань буцаж татаж асуудлуудаа 1 эргэж хараад тэгээд буцаж өргөн бариад ингээд ажлын хэсэг ажиллаад оруулж ирж байгаа юм аа. Гол асуудал.

Хоёрдугаарт, Ганхуяг сайд юу гишүүний хэлдэгчлэн тэр тусгай зөвшөөрлийн асуудлууд байж байна. Сая яг энэ тусгай зөвшөөрлийн хувьд зайлиггүй оруулах шаардлагатай болчихоод байна.

Нэгдүгээрт, төмөр зам барих асуудлыг ЗГ тусгай зөвшөөрөл өгдөг, ЗГ, бид үүнийг доош нь сайдынх нь хэмжээнд өгч байгаа. Төмөр зам барина гэдэг маань далан босгох, тэгээд тэр мэргэжлийн үүднээс шейп нь бусад дэр мод энэ тэрээ гээд л энэ бас технологийн асуудал байгаа. Гэсэн хэдий ч энэ маань Монголчуудын хувьд бас барих ийм боломж бололцоо нь бий болчихоод байна шүү дээ. Бүрэн барих боломж бололцоотой чадалтай болчихоод байна.

Тийм болохоор үүнийг сайдынх нь түвшинд тэр ЗГ дээр өгдөг биш сайд нь өгдөг болгоод тэр доош нь буулгаж ирж байгаа.

Хоёрдугаарт, технологийн хяналтыг хийх хэрэгтэй. Ер нь аливаа барилгын ажилд явцын технологийн хяналт, захиалагчийн хяналт, мэргэжлийн байгууллагууд хянах ёстой шүү дээ. Энэ хянаж байж ямар хэмжээний стандартын технологийн дагуу үйл ажиллагаа явагдаж байна гэдэг нь архивд сүүлд нь хадгалагдаад үлдэж байх ёстой ийм ач холбогдолтой. Тэгэхээр яг энэ салбар дээр урьд өмнө технологийн хяналт гэсэн зүйл байхгүй байсан юм, Ганхуяг гишүүн ээ. Тэгэхээр зайлиггүй энэ барилгын ажил жишээ нь сая Хангийн төмөр зам баригдлаа, Таван толгойн төмөр зам, Таван толгой Гашуун сухайтын төмөр зам, Зүүнбаянгийн төмөр зам баригдлаа. Эд нар дээр энэ ... /минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Нэмж хариулах, нэмж хариульга 1 минут.

Ж.Бат-Эрдэнэ: Тэгэхээр энэ барилгын ажилд зайлиггүй хөндлөнгийн технологийн хяналт зайлиггүй хийх шаардлагатай. Аливаа барилгын ажил чинь бид нар бүгд л хийж байгаа шүү дээ. Одоо авто зам дээр замын хөндлөнгийн хяналтууд мэргэжлийн байгууллагууд хийгээд явж байгаа. Зөвшөөрлийн тухай хуульд заачихсан байж байгаа. Саяын барьсан төмөр замууд дээр яах вэ, тэр

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Монголын мэргэжлийн байгууллага, МТЗ-аа дайчлаад л бид хөндлөнгөөс болоод хянаад явсан. Гэхдээ цаашидаа мэргэжлийн ийм хяналт зайлшгүй хийх ёстой. Одоо жишээ нь Баруун босоогийн төмөр зам яригдаж байна, зүүн босоо, зүүн талын төмөр замууд яригдаж байна, өшөө бид нар мөн удахгүй хурдны төмөр замаа хүртэл барих ийм зүйл ирээдүй их ойрхон болчихоод байна шүү дээ. Тийм болохоор хөндлөнгийн хяналтыг бид зайлшгүй хийхгүй болохгүй бол болчихоод байгаа юм аа. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Ингээд ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрөөтэй саналуудаар санал хураалт явуулж эхэллээ. Хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналуудаар санал, хэдэн санал байна. Энэ ар дээрээ нийт зарчмын зөрөөтэй 24, ингээд найруулгын 3, энэ дагалдаж хуульд 3, 4 хуульд өөрчлөлт орж байгаа 3 байна уу, тийм ээ, 3 хуульд өөрчлөлт орж байгаа юм байна шүү.

Гишүүд сайхан идэвхтэй сууж байгаад санал хураалтаа явуулчихъя.

Саналын томъёолол 1-ийг уншъя. Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “бусад байгууламж” гэсний өмнө “салбар зам,” гэж нэмэн, 4.1.9 дэх заалтын “зам талбай, хүлээн авах, олгох, хадгалах үйлчилгээ үзүүлэх,” гэснийг “хадгалах зам талбай” гэж, 4.1.24 дэх заалтын “аюулгүй байдлыг хангах хатуу бүртгэл, дугаар, хяналттай ашиглах” гэснийг “аюулгүй байдлыг хангахад ашиглах” гэж тус тус өөрчлөх.

Ингээд санал гаргасан ажлын хэсэг хаана байна. Ажлын хэсгийн дээр нь эхлээд танилцуулах ёстой шүү дээ. Ажлын хэсэг хэн ажлын хэсгийн ахлагч Ж.Бат-Эрдэнэ, бусад гишүүд хаана байна, энэ чинь танилцуулах ёстой шүү дээ. Ажлын хэсгээ хаясан гишүүдийнхээ танилцуулгыг аваад ир.

Ж.Бат-Эрдэнэ гишүүн, ажлын хэсгийн ахлагч, А.Адьяасүрэн гишүүн УИХ-ын гишүүн, Э.Бат-Амгалан гишүүн, Б.Баттөмөр гишүүн, Д.Бат-Эрдэнэ гишүүн, Б.Жавхлан гишүүн, Оюунчимэг гишүүн, С.Чинзориг гишүүн гэсэн ажлын хэсэг байна.

Ингээд санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Анхны зарчмын зөрөөтэй санал дээрээ уначихлаа даа. Ингээд хэн нь юу нь ажилласангүй вэ. Ажлын хэсэгт байгаа шүү дээ, Чинзориг гишүүн ээ. Таны юу ажиллахгүй байна уу? Чинзориг гишүүн ээ, төхөөрөмжөө солиод картаа хийгээд 1 ажиллаж байвал та санал гарга даа. Чинзориг гишүүний микрофоныг нээе.

С.Чинзориг: Сая миний энэ төхөөрөмж болсонгүй, маслаад санал хураалтад өгч болсонгүй. Тэгэхээр саяын санал хураалтыг хүчингүй болгоод дахин санал хураалт явуулъя гэсэн саналтай байна.

Ц.Цэрэнпунцаг: Чинзориг гишүүний гаргасан саналаар саяын хураасан саналыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Гишүүдийн 63.6% нь дэмжиж санал дэмжигдлээ. Саяын санал хураалт хүчингүй болсон учраас дахин санал хураалт явуулъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Гишүүдийн 63.6%-ийг нь дэмжиж санал дэмжигдлээ.

Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.2 дахь заалтын “технологийн” гэснийг болон 4.1.11 дэх заалтыг хасах, санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Гишүүдийн 63.6%-ийн дэмжиж, санал дэмжигдлээ.

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

3. Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалт болон 7.2 дахь хэсгийг хасах, санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Гишүүдийн 54.5% нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Санал 4. Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтын “14.1.2-14.1.6-д” гэснийг “14.1.1-14.1.4-д” гэж өөрчлөх, санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Гишүүдийн 63.6% нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Эх барьсан зөвлөхөд нь саяын энэ бичилтээ 14 бүгдийг нь задалж бичээрэй, 14-ийн 1-ийн 2-оос 14-ийн 1-ийн 6 гэгчихсэн 14-ийн 1-ийн 1-ээс 14-ийн 1-ийн 4 гэгчихсэнийг бүгдийг нь задалж бичээрэй.

5. Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтын “ашиглах зөвшөөрлийг” гэснийг хасах, санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Гишүүдийн 63.6% нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Саналын томъёолол 6. Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.27 дахь заалтын “төмөр замын тээвэр зуучлалын” гэснийг хасаж, 11.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.2.Энэ хуулийн 11.1.1, 11.1.2, 11.1.3-т заасан дүрэм, 11.1.4, 11.1.5, 11.1.7, 11.1.8, 11.1.9, 11.1.12, 11.1.14, 11.1.17, 11.1.25, 11.1.27-д заасан журам, 11.1.20-д заасан аргачлал, 11.1.21-д заасан нормыг төмөр замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, энэ хуулийн 11.1.6, 11.1.10, 11.1.11, 11.1.13, 11.1.16, 11.1.18, 11.1.19-т заасан журмыг төрийн захиргааны байгууллага тус тус батална.”, санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Яасан их журам гаргах нь вэ. Ямар юм гардаг юм бол доо.

Гишүүдийн 60 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

7. Төслийн 13 дугаар зүйлийн 13.2.1 дэх заалтын “засварлах, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийн ажлын” гэснийг “өргөтгөх, шинэчлэх, зураг төсөл боловсруулах ажлын” гэж өөрчлөн, 13.3 дахь хэсгийн “зохион байгуулна” гэсний өмнө “энэ хуулийн 11.1.25-д заасан журмын дагуу” гэж нэмэн, 13.2.3 дахь заалтын “, тусламж” гэснийг хасах, санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Чинзориг гишүүн саналаа өгөөрэй. Энэ санал уначихлаа даа. Чинзориг гишүүн ээ, таных эсрэг гарсан байна. Ажлын хэсэгт ажилласан, ажлын хэсгээс орж ирсэн саналууд шүү дээ. Чинзориг гишүүн ээ, та дахиад, бүх юмаа шатаачихлаа, бүх төхөөрөмжөө шатаачихлаа, өнөөдөр 3 дахь төхөөрөмжөө шатаалаа.

Санал гаргах уу? Энд санал гаргах хэрэгтэй. Та нар санал гаргах хэрэгтэй байна. Чинзориг гишүүн. 1 карт сугалчихсан байна шүү дээ, 9, манайх ирц хүрэхээ больчихоод байна.

Чинзориг гишүүний микрофоныг нээе. Чинзориг гишүүн ээ, санал гаргаадах уу? Чинзориг гишүүн таны микрофон нээлттэй байна, гараа битгий наад микрофондоо хүргээрэй, дахиад шатаачихна шүү. Харин хуруу нь дандаа хуруугаараа юм хийдэг юм уу.

С.Чинзориг: Энэ миний техник болохгүй байна. Энэ Ганбаатараас болоод байгаа юм уу, яагаад байгаа юм дандаа шатчихаад байх юм. Тэгээд саяын санал хураалтыг хүчингүй болгоод ахиж санал хураалт явуулж өгөөч.

Ц.Цэрэнпунцаг: Чинзориг гишүүний гаргасан саналаар саяын

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хураасан санал хураалтыг хүчингүй болгоё. Санал хураалт.

Гишүүдийн 70% нь дэмжиж, саяын санал хураалт хүчингүй боллоо.

Ингээд дахин санал хураалт явуулъя. Санал хураалт.

Гишүүдийн 70% дэмжиж, санал дэмжигдлээ.

Санал 9. Төслийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “тусгай зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүний нөөцийн болон техникийн чадвар, чадвартай эсэх, төмөр замын объект, үйл ажиллагаанд тавигдах” гэснийг “энэ хуулийн 14.3-т заасан” гэж өөрчлөх, санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Гишүүдийн 70% нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Санал 10. Төслийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “газар нь төмөр замын зурвас газарт хамаарна” гэснийг “газрыг төмөр замын зурвас газар гэнэ” гэж өөрчлөн, мөн хэсгийн “шугамын” гэснийг болон 17.3 дахь хэсгийг хасах, санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Гишүүдийн 70% нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Дараагийн санал. Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1.5, 14.1.6 дахь заалт, 14.4 дэх хэсэг болон 14.3 дахь хэсгийн “, 5.12, 5.13” гэснийг тус тус хасаж, 14.1.1 дэх заалтын “суурь бүтэц барих” гэсний дараа “, зураг төсөл боловсруулах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ” гэж нэмэх, санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Гишүүдийн 60 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Санал 11. Төслийн 18 дугаар. Ирцгүй ирц хүрэхээ больчихлоо. Чинзориг гишүүний карт болохгүй байгаа юм биш үү,

Санал 11. Төслийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “газар нь төмөр замын хамгаалалтын бүсэд хамаарна” гэснийг “хэсэгчилсэн хамгаалалтын бүстэй байж болно.” гэж өөрчлөн, 18.2 дахь хэсгийг хасах, санал гаргасан ажлын хэсэг.

Асуулт байна. Асуулт байна даа, энэ дээр. Би асуулт асуугаадахъя. Ажлын хэсгээс 11 дээр энэ газар нь төмөр замын хамгаалалтын бүсэд хамаарна гэснийг хэсэгчлэн хэсэгчилсэн хамгаалалтын бүстэй байж болно оо гэж өөрчилжээ. Ажлын хэсгээс энэ өөрчилсөн шалтгаанаа тайлбарлах уу? Ажлын хэсгийн ахлагч Бат-Эрдэнэ гишүүн. Ж.Бат-Эрдэнэ гишүүн.

Ж.Бат-Эрдэнэ: Төмөр зам маань хамгаалалтын бүс, тусгай бүс эд нар гээд бас 2 янзын бүс байгаад байгаа юм. Тэгээд хамгаалалтын бүс бол үндсэндээ төмөр замын аюулгүй байдал бий болгох, аюулгүй байдлыг хангах, гаднын нөлөөллөөс хамгаалах, мал болон бусад байгалийн болзошгүй аюул үер ус энээ тэрээгээс хамгаалах ийм нөхцөл байдлыг бий болгохын тулд бас хамгаалалтын бүсийг бий болгох ийм зайлиггүй шаардлага гараад байгаа юм. Энэ нь бүр ингээд аваад хамгаалаад өөрийн болгоод өөрийн эзэмшил дээр эд нар хийх гэхээсээ илүү тухайн газар нь далан барих ч байдаг юм уу тодорхой хэмжээний салхи шуурганаас хамгаалах эд нар гэсэн 1 ийм бүсүүд бий болох ийм боломжтой байгаа юм. Гэхдээ энэ дээр түрүүний миний хэлсэнчлэн шууд өөрийн эзэмшилд эд нар ингээд авчихгүй. Мэдээж орон нутагтай зохицно, ярилцана, тэгээд тэнд нь юу гэдэг юм хаалт хамгаалалт тавих ч байдаг юм уу, тодорхой хэмжээний мал орохгүй байх ч байдаг юм уу, 1 иймэрхүү зүйлтэй хамгаалалтын бүс өнөөдрийг хүртэл орон нутагтайгаа зөвшилцөөд

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хийгдээд ирчихсэн юм байж байгаа.
Үүнийг л хэлж байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Энэ ер нь хуучин явж ирсэн энэ жишгээсээ нэг их агуулгын хувьд хазайгаагүй юм байна тийм үү гэж ойлголоо, энэ дээр.

18. Ингээд санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Гишүүдийн 60 хувь нь дэмжин, санал дэмжигдлээ.

Санал 12. Төслийн 23 дугаар зүйлийн 23.3.1, 23.3.2 дахь хэсгийн дугаарлалтыг сольж, 23.3.2 дахь хэсгийн “тухайн төмөр замын суурь бүтэц” гэснийг, 23.4.10 дахь заалтын “эрх бүхий байгууллагын гүйцэтгэсэн” гэснийг тус тус хасах, санал гарсан ажлын хэсэг, санал хураалт.

Гишүүдийн 70% нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Санал 13, ажлын хэсгийн санал 13. Төслийн 26 дугаар зүйлийн 26.1.2 дахь заалтыг “суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгчид галт тэрэг харилцан чөлөөтэй нэвтрэх нөхцөлийг тусгасан гэрээ байгуулсан байх;” гэж, 26.1.3 дахь заалтыг “суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч болон тээвэрлэгч нь энэ хуулийн 25.1-д заасан үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан гэрээ байгуулсан байх;” гэж тус тус өөрчлөх, санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Гишүүдийн 70% нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Ажлын хэсгийн санал 14. Төслийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийн “өмчлөгч” гэсний дараа “, эзэмшигч нь” гэж нэмэх, санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Гишүүдийн 70% нь дэмжиж, санал дэмжигдлээ.

15. Төслийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийн “байх зарчим баримтална” гэснийг “байна” гэж өөрчлөн, 31.2 дахь хэсгийн “бусад дэд бүтэцтэй” гэсний өмнө “энэ хуулийн 31.1-д зааснаас” гэж нэмэн, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 31.4 дэх хэсэг болон Тайлбар тус тус нэмэх:

“31.4.Төмөр замын суурь бүтэцтэй огтлолцох авто зам болон бусад төрлийн суурь бүтцийн зураг төслийг боловсруулахдаа төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөнө.

Тайлбар: Энэ хуулийн 31.1-д заасан “бусад төрлийн суурь бүтэц” гэж метро, трамвай, соронзон болон тусгай загвар бүхий түүнтэй адилтгах нийтийн тээврийн төмөр замыг ойлгоно.”, санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Гишүүдийн 70% нь дэмжиж, санал дэмжигдлээ.

16. Төслийн 32 дугаар зүйлийн “зам” гэснийг “замын үйлчилгээ” гэж, 32.2 дахь хэсгийн “замтай” гэснийг “замын үйлчилгээтэй” гэж, 32.3 дахь хэсгийн “замын холболтын цэгийг” гэснийг “замыг холбох, өргөтгөх, салаалахтай холбоотой асуудлыг суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгчийн саналыг харгалзан” гэж тус тус өөрчлөн, 32.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Салбар замын үйлчилгээнд ачаа ачих, буулгах, сэлгээний ажил хийх, ачаа хүлээн авах, олгох, хадгалах, шилжүүлэх зэрэг үйл ажиллагаа хамаарна.”, санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Гишүүдийн 70% нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Санал 17. Төслийн 39 дүгээр зүйлийн нэрийн “бүрэлдэхүүнд тавигдах” гэснийг “бүрэлдэхүүн, түүний эд ангийг үйлдвэрлэх, угсрах, засварлахад тавих”

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

гэж өөрчлөх, санал гаргасан, ажлын хэсэг, санал хураалт.

Гишүүдийн 60 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

18. Төслийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсгийн “газраар” гэсний дараа “хүн, техник хэрэгсэл” гэж нэмэн, 43.5 дахь хэсгийн “тээвэрт тусгай зориулалтын багаж, хэрэгсэл ашиглах” гэснийг “тээвэрт ашиглах тусгай зориулалтын багаж хэрэгсэл нь бүртгэл, дугаар, хяналттай байх бөгөөд түүнийг ашиглах” гэж өөрчлөх, санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Гишүүдийн 70% нь дэмжиж, санал дэмжигдлээ.

19. 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсгийн “тээврийн байгууллага” гэснийг “суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч, тээвэрлэгч, салбар зам эзэмшигч” гэж өөрчлөх, санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Гишүүдийн 60 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

20. Төслийн 44 дүгээр зүйлийн 44.4 дэх хэсгийн “зорчигч болон ачаа тээврийн тарифыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд албан ёсоор мэдээлэхгүйгээр” гэснийг “тээврийн тарифыг цахим хуудас, мэдээллийн самбар, мэдээллийн бусад хэрэгслээр олон нийтэд албан ёсоор мэдээлэхгүйгээр” гэж өөрчлөх, санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Гишүүдийн 70% нь дэмжиж, санал дэмжигдлээ.

21. Төслийн 44 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 44.5-44.7 дахь хэсэг нэмэх:

“44.5. Төрийн захиргааны байгууллагын дэргэд төмөр замын тээврийн тарифыг оновчтой тогтоох

асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий төмөр замын тээврийн тарифын орон тооны бус зөвлөл ажиллах бөгөөд дүрмийг нь төмөр замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

44.6. Энэ хуулийн 44.5-д заасан зөвлөлийн дарга, гишүүнийг төмөр замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн төрийн захиргааны байгууллагын дарга томилж, чөлөөлөх ба нарийн бичгийн дарга нь орон тооны байна.

44.7. Зөвлөл нь эдийн засаг, хөгжлийн, төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын төлөөллөөс гадна ашигийн ба ашигийн бус хуулийн этгээдийн төлөөллийг оролцуулсан таван хүний бүрэлдэхүүнтэй байна.”, санал гаргасан ажлын хэсэг.

Ганхуяг гишүүн асуулттай байна.
Ганхуяг гишүүн асуултаа асууя.

Х.Ганхуяг: Энэ 44.5-ын асуудлыг л асууя л даа. Энэ орон тооны бус зөвлөл үнэ тогтоох, зам тээврийн тариф тогтооно гэсэн байх юм. Энэ тэгээд буцаад эд нар чинь ингээд хамаг юмныхаа үнийг энэ яам нь журам гараад батлаад тогтоогоод байх юм уу гэдэг асуулт байна. Энэ чинь бид нар энэ эрчим хүчний салбар чинь дампуурлаа, энэ либералчлаад үнэ чөлөөлье гээд нөгөө талдаа ярьж байдаг. Тэгээд бид нар чинь хэрвээ цаашидаа энэ төмөр замын суурь бүтцийг хувийн хэвшил хийхийг зөвшөөрөх гэж байгаа бол олон тооны хувийн төмөр замтай болох юм бол энэ тариф тогтооно гэдэг асуудал чинь цаашидын төмөр замын хөгжилд чинь сөрөг нөлөөтэй юм биш үү л гэж л асуулт асуумаар байх юм. Сайдаас асууя даа. Сайд нь оруулсан юм биш үү.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн ахлагч Ж.Бат-Эрдэнэ гишүүн хариулъя.

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Ж.Бат-Эрдэнэ: Би түрүүн тайлбар дээр хэлсэн шүү дээ. Ер нь либералчилж байгаа, төмөр замынхаа энэ салбарыг либералчилж, нээлттэй болгож, өрсөлдөөнийг бий болгож, олон ААН, олон компаниуд бий болгох энэ нөхцөл байдлыг бид нар чинь гаргаж ирж байгаа шүү дээ. Тэгэхээр төмөр зам өөрөө том хөрөнгө оруулалт оруулж байдаг нөлөө бүхий бас тодорхой хэмжээний хөрөнгө оруулагчид орж байдаг, тодорхой жишээ нь баруун босоогийн асуудал яригдлаа гээд тэгэхэд тэнд хүссэн хүсээгүй бид нар чинь өөрсдөө төр өөрсдөө байж чадахгүй байна шүү дээ. Концессоор өгч байгаа. 20 жилийн дараа төр 100% хүлээж авахаар ч байдаг юм уу. Тэгэхээр энд нөгөө 1 үнийн ялгаа гарах, бие биедээ өөрсдөө жишээ нь тээвэрлэгч байх юм бол өөрсдөдөө давуу тал гаргах, өөрийнхөө тээврийг тээгээд өөрийнхөө ачааг ч тээгээд, жишээ нь 1 уурхай руу төмөр зам тавилаа гэж бодоход зөвхөн өөрийнхөө ачааг зөөгөөд бусдад боломж олгохгүй ч байх юм уу. Ийм нөхцөл байдал олон улсад маш их гардаг, олон улсад маш их гардаг. Бид нар төмөр замын асуудлаар Австралид явж байхад 1 чиглэл рүү 5 төмөр зам тавьсан асуудал байж байгаа шүү дээ. Нэгэндээ ерөөсөө тээвэрлэлт хийлгэхгүйгээр зэрэгцээд 5 хамгийн муу жишээ 5 тээвэрлэгч, 5 суурь бүтэц эзэмшигч зэрэг зэрэг барьчихсан ийм юу байгаад байгаа юм. Тэгэхээр бид анхнаасаа бас 1 хоорондын зохицуулалтыг нь хийе гэж байгаа юм аа.

Ер нь тарифын аргачлалыг сайд батлаад өгчихнө, ААН компаниуд өөрсдийнхөө тарифыг өөрсдөө гаргана, ганцхан тэнд нь дүгнэлт хийх ерөнхийдөө тариф нь ижил байна уу гэдэг дээр дүгнэлт хийх ийм хөндлөнгийн байгууллага л бид нар бий болгож байгаа юм. Жишээ нь бид нар Эрчим хүчний зохицуулах хороо эд нар гэж бас байдаг шүү дээ. Хороо гэдэг байх аа. Энд чинь эрчим хүчийг давамгайл байдал гаргачихгүй 1 газар нь үнэтэй, 1 газар нь хямдхан байхгүй гээд энд зохицуулалтыг улс даяар хийж байгаа Ерөнхий сайдын

дэргэдэх ийм байгууллага байдаг юм шүү дээ. Энэ жишээ нь энэ зөвлөл нь агентлагийнхаа дэргэд байж байгаа байхгүй юу. Тэнд 1 их том эрх өгчхөж байгаа зүйл биш. Ер нь тариф маань ямаршуу түвшинд явж байна жигд явж байна уу, 1 газар нь илүү үнэ өгчхөөд нөгөө газар нь бие биедээ давуу эрх өгчхөөд байна уу, тарифын ялгаа гараад байна уу гэдэг дээр л судалгаа хийж дүгнэлт гаргах л ийм л зөвлөл болж байгаа юм шүү. Түүнээс биш ажиллахын хувьд либералчилсан чиглэлээр ажиллаад явах юм.

Ц.Цэрэнпунцаг: Ганхуяг гишүүн тодруулж асууя, тодруулж асууя 1 минут.

Х.Ганхуяг: Энэ үнэ тогтооно гэдэг маань л жоохон энэ чинь тариф л тогтооно л гэгчихсэн байна шүү дээ. Тэгээд тээвэрлэлтийн, тэгээд ихэнхдээ энэ чинь бүх төмөр замууд чинь төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр л явж байгаа байлгүй дээ. Тэгээд гэрээгээрээ тэр чинь эргээгээд хэдэн тонныг ямар үнээр тээвэрлэх энэ чинь гэрээн дээрээ тусгачхаж болохоор л асуудал байх юм. Тэгээд шударга өрсөлдөөний газар тэгээд бас байгаа. Тэгээд энэ хэдэн орон манайх ингэж манайхтай адилхан ингэж тариф тогтоодог юм. Энэ яг төмөр замын тээвэр дээр.

Ц.Цэрэнпунцаг: Ж.Бат-Эрдэнэ гишүүн яах уу, нэмж хариулах уу? Ж.Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг нээе дээ.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ төрийн захиргааны байгууллагын дэргэд төмөр замын тээврийн тарифыг оновчтой тогтоох асуудлаар гэж байгаа шүү. Оновчтой тогтоох асуудлаар өөрөөр хэлбэл агентлагийнхаа дэргэд байж байгаа асуудлаар дүгнэлт зөвлөмж гаргах үүрэг бүхий төмөр замын тарифын орон тооны бус зөвлөл ажиллах гэж байгаа юм шүү бөгөөд дүрмийг нь Төмөр замын асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүн батална

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл яамны сайд нь ингэж дүрмийг нь баталж өгнө. Орон тооны бус зөвлөлд дүгнэлт гаргах зөвлөмж гаргах юм шүү.

Хуульдаа аль хэдийн хэд дээр заалттай байгаа билээ? Яг төмөр замын байгууллага өөрсдийнхөө тарифыг тогтооно гэсэн бүр үг үсэгтэй байгаа, тэр хэдийн хэд байна хэлээд өг дөө надад. Тариф хэд дээр байна. Энд ингэж байгаа шүү. Төмөр замын тээврийн байгууллага нь энэ хуулийн 11.1.20-д заасан аргачлалын дагуу. Энэ аргачлал ... /минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Ж.Бат-Эрдэнэ гишүүнд нэмж 1 минут өгье.

Ж.Бат-Эрдэнэ: Энд ингэж байгаа шүү. Төмөр замын тариф 44 дүгээр зүйл дээр 44.1 Төмөр замын тээврийн байгууллага нь энэ хуулийн 11.1.20-д заасан аргачлалын дагуу тариф тогтооно оо гэж байгаа юм. Төмөр замын байгууллага өөрөө тогтоох юм шүү, ААН-үүд нь тарифаа тогтооно. Дээдх нь зөвхөн аргачлал зөвлөмж л өгөх байхгүй юу. Энэ аргачлалыг харин сайд баталчихъя. Сайдаар аргачлалыг нь батлуулчих, төмөр зам дотор чинь тэр ачааны асуудлууд байж байна. Ямар аюулгүй ачаа тээвэрлэхэд тийм байна, овор ихтэйг нь ачаад тээвэрлэхэд тийм байна ч гэдэг юм уу. Тэгээд тонн шатахуун бүхий л зардлуудыг тооцож ингэж тарифаа тогтооно оо гэсэн аргачлалыг нь сайд батлаад л өгчих юм. Тэгээд л бол оо. Төмөр замын байгууллага өөрсдөө тогтооно шүү.

Ц.Цэрэнпунцаг: Энэ тарифтай холбоотой асуудал явж байгаа учраас би дахиад 1 асуулт асуучихъя. Яагаад гэвэл энэ Байнгын хороон дээр яг тодорхой төстээр 1 санал гомдол ирсэн юм. Энэ өөрөө 1 салаа төмөр замтай хүн цаашаа нөгөө залгаад цаад талд нь замын нааш давхар 2 төмөр зам эзэмшидэг л хүмүүс юм шиг байна лээ. Тэгээд наагуур нь дамжиж өнгөрч байгаа нөхөр нь тарифаа

тохирдоггүй, 6, 7 жил шүүхээр явж байгаа гээд. Тэгээд би 1 ажлын хэсэг дээрээ наадхаа аваачиж танилцуулаарай, энэ асуудал энэ хуулиар шийдэгдэх ёстой гэсэн. Тэгэхээр жишээлбэл энэ Эрдэнэтийнх юм шиг Эрдэнэтэд байсан байх. Энэ төмөр замын нөхөр нь тэгээд нөгөө нөхөр нь замыг нь ашиглачихдаг, тэгээд нөгөөдөх нь энэ миний замыг ашиглачихлаа, ингээд төлбөрөө нэхдэг, ингээд л ийм асуудал гарсан юм байна лээ. Үүнийг бол 1 мөсөн иймэрхүү асуудлуудыг шийдэх ёстой байгаа юм. Тэгэх дээр энэ хуулиар би үүнийг шийдэгдэх ёстой шийдэгдэх байх гэж харж байгаа юм.

Энэ ажлын хэсгийн ахлагч Ж.Бат-Эрдэнэ гишүүн хариулъя.

Ж.Бат-Эрдэнэ: 1 маргаантай асуудлыг шийдсэн шүү. Энэ хуульд оруулаад. Одоо энэ манай эрчим хүчний хуульд юунд салбар дээр ч их байдаг, дэд бүтцийн салбар дээр. Улсын өмч бүхий том магистрал шугамаас хувийн компани өөрсдөө шугамаа авчхаад жишээ нь дэд бүтцийн чиглэлээр, дулааны чиглэлээр, цахилгааны чиглэлээр юу авчхаад зөвшөөрөл авчхаад тэгээд тэрийгээ цаашаа зараад байдаг бусад компаниудад. Өөрийнхөө хувийн хөрөнгөөр барьчихаад тэгээд цаашаа зараад дахиад салбарлуулаад зараад байдаг юм бол хаа сайгүй байгаа шүү дээ. Яг үүнтэй адилхан 1 нүүрс буулгах талбай гэж авчхаад тэр лүүгээ төмөр зам татчихаад тэгээд цаашаагаа дахиад ААН өгөхөөр тэрэндээ зараад байдаг. Тэгэхээр үүнийг таслан зогсоогоод ямар ч байсан тарифын хувьд ААН өөрөө тогтооно гэдгээрээ тэр салбар замын ААН өөрийнхөө тарифыг нэгдүгээрт тогтоочихно. Тэрийг нь дээрээсээ яах вэ, хянаад үзчихнэ. Нөгөөтээгүүр цаашаагаа ингээд зараад байдаг асуудлуудыг нь болиулж байгаа шүү. Өөрөөр хэлбэл, магистрал шугам эзэмшигч нь тэндээ цаашаа өөрөө зөвшөөрлүүдээ өгөөд, энд 1 ААН бий боллоо гэхэд ийшээгээ зөвшөөрөл нь өгөгдөөд, цаашаагаа салбарлаад салбарлаад явах боломж бололцоо нь

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

нээгдчихнэ. Эхний хүн нь цаашид зараад байдаг нөхцөл байдлыг л хаачхаж байгаа юм шүү. Энэ бол юу гэдэг юм төрийн өмч бүхий нийтийн энэ шугамыг л зараад байгаа асуудал гараад байгаа шүү дээ. Ер нь эрчим хүчин дээр их байж байна, манай дулааны шугамууд дээр маш их байна, тийм, үүнийг энэ дээр засаж байгаа юм шүү.

Ц.Цэрэнпунцаг: Ж.Бат-Эрдэнэ гишүүний хариултаар ингэж ойлголоо. Ер нь ингээд салаа зам цаашаа 1 километр зам бариг, цаашаа дахиад 2 дахь, 3 дахь залгаад барих нь бол нэгдсэн 1 бодлогоор өгөх юм байна. Зөвшөөрлийг нь тийм үү. Тэр нэг 1 километр, 2 километр замтай нөхөр бол цаашаа дахиж залгаж өөр газрууд өгөх үү гэдгээ шийдэхгүй. Тэрний тарифын асуудлыг шийдэхдээ энэ тариф тогтоож байгаа энэ зөвлөл чинь шийдэх юм байна тийм ээ. Тэгэхдээ нэг ийм юм бид нар түрүүн, бас энэ Ганхуяг гишүүний хэлж байгааг анхаарах хэрэгтэй л дээ. Ер нь энэ тэр шүүхээс гаргасан тэр шүүхээс өгсөн шийдвэр дээр энэ хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах шударга өрсөлдөөний хамгаалах байгууллага бол энэ дээр бас тодорхой үүрэг рольтой. Энэ үнэ тарифыг мөлжлөг хийгдэж байна уу үгүй юу, шударга үнэ тариф тогтоож байна уу үгүй юу гэдгийг одоо энэ хэрэглэгчдийн эрх ашгийг, шударга өрсөлдөөн манай агентлагийн нэр чинь юу билээ? Шударга өрсөлдөөн хэрэглэгчдийн төлөөх газар, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөөх газар гэж. Энэ хянаж давхар явж байх ёстой юм байна лээ. Үүнийг сайн оруулж өгөх хэрэгтэй. Тэгээд хэрвээ нөгөө эзэмшигч маань энэ дээрээс энэ зөвлөл энэ тарифыг нь янз бүрээр тогтоогоод энэ нь хангалтгүй байна. Миний хөрөнгө оруулалтад дүйцэж энэ шударга бус байна гэвэл үүнийг нь бас цааш нь энэ хэрэглэгчид эзэмшигчдийн эрх ашгийг бас хангаж ажилладаг энэ хамгаалалт нь байгаа байх гэж бодож байна.

Ингээд санал хураалт явуулъя.
Санал хураалт.

Гишүүдийн 60 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Ажлын хэсгийн санал 22. Төслийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсгийн “2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс” гэснийг “2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс” гэж өөрчлөх, санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Гишүүд анхааралтай байгаарай, санал хураалт. Санал хураалт гишүүд ээ, Ганбаатар сайд аа, саналаа өгөөрэй.

Булгантуяа гишүүн та эсрэг өгсөн байна. Биш ээ, уучлаарай, Ганбаатар гишүүн. Ганбаатар гишүүний төхөөрөмж ажиллахаа больжээ. Ганбаатар гишүүн та юугаа соль доо, төхөөрөмжөө солиод санал гаргах уу. Ганбаатар гишүүн та санал гаргая. Ганбаатар гишүүний микрофоныг нээе дээ.

Ж.Ганбаатар: Байнгын хороон дарга аа, юу төхөөрөмж ажилласангүй, би төхөөрөмжөө солиод суучихлаа. Тэгэхдээ энэ ер нь олон төхөөрөмж ажиллахгүй байна шүү. Энэ Байнгын хорооныхонд яахгүй бол. Ер нь бараг ингээд дээрээсээ эхлээд бараг олон төхөөрөмжүүд ажиллахгүй болчихлоо шүү дээ. Үүнийг янзалж өгөхгүй бол болохгүй юм байна гэж.

Ц.Цэрэнпунцаг: Ганбаатар гишүүний гаргасан саналаар саяын хураасан санал хураалтыг хүчингүйд тооцъё гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалт, техникийнхэн чинь яачхав.

Гишүүдийн 70% нь дэмжиж, саяын санал хураалт хүчингүй боллоо. Ингээд саяын санал хураалт хүчингүй болсон учраас дахин санал хураалт явуулъя. Санал хураалт.

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Гишүүдийн 70% нь дэмжиж, санал дэмжигдлээ.

23. Төслийн 26 дугаар зүйлийн 26.1.4 дэх заалтын дугаарыг “26.6” гэж, 47 дугаар зүйлийн 47.1.2 дахь заалтын дугаарыг “47.2” гэж, 47.1 дэх хэсэг, 47.1.1 дэх заалтын дугаарыг нэгтгэн “47.1” гэж, мөн төсөлд зүйл, хэсэг, заалт хасах, нэмэх саналтай уялдуулан төслийн нэр томъёог жигдлэх, холбогдох зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх засварыг хийх, санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Гишүүдийн 70% нь дэмжиж, санал дэмжигдлээ.

24. Төслийн 10 дугаар зүйлд тусгагдсан зохицуулалтыг төслийн үзэл баримтлалд тусгагдсаны дагуу дэмжсэнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасныг үндэслэн “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тогтоолын төслийг боловсруулж, хэлэлцүүлэх, санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Гишүүдийн 70% нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Зарчмын зөрөөтэй саналууд дуусаад, одоо ингээд найруулгын 3 санал байна.

Гишүүд анхааралтай суугаад найруулга дээр нь анхаараарай.

Ингээд найруулгын санал 1.

Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.7 дахь заалтын “осол” гэсний, 11.1.17 дахь заалтын “салбарын” гэсний, 4 дүгээр зүйлийн 4.21 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, 27 дугаар зүйлийн

27.2.6 дахь заалт, 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийн “аюулгүй байдал” гэсний, 42.2 дахь хэсгийн “дүрэм” гэсний өмнө болон 12 дугаар зүйлийн гарчгийн “Төмөр замын” гэсний дараа “тээврийн” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1.18 дахь заалт, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийн “ажилтан” гэсний, 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсгийн “ажилтанг” гэсний өмнө “тээврийн байгууллагын” гэж, 34 дүгээр зүйлийн 34.4 дэх хэсгийн “сэргийлэх” гэсний өмнө “урьдчилан” гэж тус тус нэмэх, санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Ганбаатар гишүүн ээ, саналаа өгөөрэй. Та ингээд мартчихаад байна.

Гишүүдийн 70% нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Найруулгын санал 2.

Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.19 дэх заалтын “баримт бичгийг” гэснийг “хуваарийг” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалтын “газар олгох, чөлөөлөх” гэснийг “газар эзэмшүүлэх эрх олгох, газар чөлөөлөх” гэж, 10 дугаар зүйлийн гарчиг, 10.1 дэх хэсэг, 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсгийн “эрхэлсэн” гэснийг “хариуцсан” гэж, 10 дугаар зүйлийн 10.2.9, 11 дүгээр зүйлийн 11.1.17 дахь заалтын “ажилтан бэлтгэх, давтан сургах” гэснийг “ажилтан сургах, давтан сургах, мэргэшүүлэх” гэж, 10.2.11 дэх заалтын “ажиллагаанд” гэснийг “ажилд” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1.10 дахь заалтын “огтлолцох” гэснийг “нэвтрэх” гэж, 11.1.25 дахь заалтын “техник, технологийн” гэснийг “техникийн” гэж, “хөрөнгийг” гэснийг “эх үүсвэрийг бүрдүүлэх” гэж, 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн “тээврийн аюулгүй байдлыг хангахад зориулагдсан” гэснийг “тээвэрт ашиглагдах” гэж, 14 дүгээр зүйлийн 14.1.3 дахь заалтын “түүний эд ангийг” гэснийг “тэдгээрийн эд анги” гэж, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “бүсэд хамааруулна” гэснийг “бүс гэнэ” гэж, 16.2 дахь хэсгийн

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

“журмаар” гэснийг “журамд тусгагдсанаас бусад үйл ажиллагаа явуулахыг” гэж, 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийн “замыг” гэснийг “замын суурь бүтцийг” гэж, 34 дүгээр зүйлийн 34.8 дахь хэсгийн “журамд” гэснийг “журам, зааварт” гэж, 36 дугаар зүйлийн 36.4 дэх хэсгийн “тээшийг олгох үед” гэснийг “тээшинд” гэж, 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийн “техник хэрэгслийн бэлэн байдлыг хангаж, материалын нөөцийг бүрдүүлсэн” гэснийг “техник хэрэгсэл, материалын нөөцийн бэлэн байдлыг хангасан” гэж, 42.6.3 дахь заалтын “ачааг” гэснийг “ачаа, тээш, ачаан тээшийг” гэж, 44 дүгээр зүйлийн 44.3 дахь хэсгийн “Тарифын” гэснийг “Тээврийн тарифын” гэж, “хүчин төгөлдөр болохоос” гэснийг “мөрдөж эхлэхээс” гэж, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийн “дүрэмт” гэснийг “албаны” гэж, 47.1.1 дэх заалтын “олгох;” гэснийг “олгоно.” гэж, 47.1.2 дахь заалтын “тэтгэмж” гэснийг “тусламж” гэж, “зохицуулах;” гэснийг “зохицуулна.” гэж, “дотоод” гэснийг “хөдөлмөрийн дотоод” гэж тус тус өөрчлөх, санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Энэ санал уначихлаа. Ундрам гишүүний санал эсрэг гарчихсан байна. Ундрам гишүүн санал гаргая.

Ч.Ундрам: Дарга аа, энэ миний төхөөрөмж ажилласангүй, санал хураалтыг хүчингүй болгож, дахиж санал хураалт зохион байгуулж өгөөч.

Ц.Цэрэнпунцаг: Ундрам гишүүний гаргасан саналаар саяын хураасан санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

Гишүүдийн 70% нь дэмжиж, саяын санал хураалт хүчингүй боллоо. Ингээд саяын санал хураалт хүчингүй болсон учраас дахин санал хураалт явуулъя, санал хураалт.

Гишүүд ээ, анхааралтай байгаад саналаа өгөөрэй.

Гишүүдийн 70% нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Найруулгын санал 3.

Төслийн ТАВДУГААР БҮЛЭГ-ийн нэрийн “ТЭЭВРИЙН” гэснийг, 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсгийн “төмөр замын суурь бүтцийн” гэснийг, 23 дугаар зүйлийн 23.3, 23.4.1, 23.4.5, 23.4.6, 23.4.7, 23.4.9 дэх заалтын “төмөр замын” гэснийг, 40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсгийн “ашиглагдаагүй үед” гэснийг, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийн “байгууллагын ажилтан дараах нийгмийн баталгаагаар хангагдана.” гэснийг, 47.1.1 дэх заалтын “төмөр замын тээврийн” гэснийг тус тус хасах, санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Гишүүдийн 70% нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Ингээд энэ дээр ажлын хэсгийн ахлагч Ж.Бат-Эрдэнэ гишүүн гаргасан зарчмын зөрөөтэй санал байна. Тийм ээ. Энэ Төмөр замын тухай хууль 14 дүгээр, саналын томъёоллыг нь уншъя. Хуулийн Төслийн 14 дүгээр зүйлийн 14.4-ийн дараа, 14.5. энэ хуулийн 14.1.2, 14.1.3, 14.1.4-т заасан тусгай зөвшөөрлийг нэг хуулийн этгээдэд давхардуулан олгохыг хориглоно гэж нэмэх. Зөв байна уу, Бат-Эрдэнэ гишүүн ээ. Саяын яг энэ уншсан томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Гишүүдийн 60 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Ингээд дагаж хуульд орох өөрчлөлт 4 хууль дээр байна. Тийм ээ, өөрчлөлт орох юм байна аа.

Ингээд Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

зөрөөтэй саналыг томъёоллыг та бүхэндээ уншъя.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт, 14.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “алдагдсан үйл явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг аваагүй буюу зохих ёсоор аваагүй, мэдээлээгүй, ангиллыг буруу тогтоосон, сэргээн босгох, шинжлэн шалгах үйл ажиллагаанд” гэснийг “алдагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг аваагүй, осол, зөрчлийг шинжлэн шалгахад болон төмөр замын суурь бүтцийг сэргээн босгох үйл ажиллагаанд” гэж, 2 дахь хэсгийн “талаарх олон улсын гэрээг” гэснийг “дүрэм, журмыг” гэж тус тус өөрчлөх, санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Гишүүдийн 70% нь дэмжиж, санал дэмжигдлээ.

2. Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 14.10 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.1 дэх заалтын “ердийн хөсөг, тээврийн хэрэгслийг” гэснийг “ердийн хөсгийг” гэж, 4 дэх хэсгийн “Хуулиар хориглосон” гэснийг “Шаардлага хангаагүй” гэж, “хэрэгсэл, технологийг” гэснийг “хэрэгслийг” гэж тус тус өөрчлөн, 3 дахь хэсгийн 3.2 дахь заалтын “байгууламж барьсан,” гэсний дараа “объект байрлуулсан,” гэж, 5 дахь хэсгийн “Суурь бүтцийн” гэсний өмнө “Төмөр замын” гэж, “эзэмшигч нь” гэсний өмнө “өмчлөгч,” гэж, “саад” гэсний өмнө “үндэслэлгүйгээр” гэж, мөн хэсгийн болон 6 дахь хэсгийн “мянган” гэсний өмнө “нэг” гэж тус тус нэмэх, санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Гишүүдийн 72.7 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

3. Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 14.10 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн “ажиллагаа эрхлэхдээ” гэснийг “ажиллагааг” гэж, 7.3 дахь заалтын “шилжүүлсэн” гэснийг “шилжүүлж”

гэж тус тус өөрчлөн, мөн хэсэгт “7.4.бусдын тусгай зөвшөөрлөөр эрхэлсэн” гэсэн агуулгатай заалт нэмэх, санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Гишүүдийн 63.6% нь дэмжиж санал дэмжигдлээ.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрөөтэй саналын томъёолол байна. 3 саналын томъёолол байна шүү.

1-д, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 29.1.12 дахь заалтын “техник, эдийн засгийн үндэслэл,” гэснийг хасаж, мөн зүйлийн “дараах” гэснийг “29.1.12 дахь” гэж, 29.1.12 дахь заалтын “тус тус” гэснийг “зөвшөөрөл тус бүрд” гэж тус тус өөрчлөх, санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Гишүүдийн 63.6% нь дэмжиж, санал дэмжигдлээ.

2. Төслийн 2 дугаар зүйлийн “дараах” гэснийг “29.1.1, 29.1.2, 29.1.3 дахь” гэж, мөн зүйлийн 29.1.1, 29.1.2 дахь заалтын “тус тус” гэснийг “зөвшөөрөл тус бүрд” гэж, 29.1.2 дахь заалтын “түүний эд ангийг” гэснийг “тэдгээрийн эд анги” гэж тус тус өөрчлөх, санал гаргасан ажлыг хэсэг, санал хураалт.

Гишүүдийн 63.6% нь дэмжиж, санал дэмжигдлээ.

3. Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмж, 3 дугаар зүйлийн дугаарыг “4” гэж өөрчлөх:

“3 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “29 дүгээр зүйл” гэснийг “29 дүгээр зүйлийн 29.1.4-29.1.11 дэх заалт” гэж өөрчилсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг.

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Энэ 29.1.4-өөс 29.1.11 гэдгээ бүгдийг нь салгаж бичээрэй. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Гишүүдийн 54.5% нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Булгантуяа гишүүн дэмжсэн байгаа шүү. Дэмжсэнээр бүртгээрэй, протоколд тэмдэглээрэй.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан 2 санал байна. Зарчмын зөрөөтэй 2 санал байна.

1. Төслийн 1 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Баттөмөр гишүүн санал гаргах уу? Баттөмөр гишүүн. Баттөмөр гишүүний микрофоныг нээе дээ.

Б.Баттөмөр: Би энэ саналыг саяын саналыг дэмжсэн юм аа. Тэгсэн энэ аппарат ажилласангүй. Яаж ч дараад ажилласангүй, дахиж санал хураалгаж өгнө үү.

Ц.Цэрэнпунцаг: Баттөмөр гишүүний саналын төхөөрөмж ажиллаагүй учраас саяын санал нь эсрэг гарсан байна. Ингээд саяын хураасан саналыг хүчингүй болгож өгөөч гэсэн Баттөмөр гишүүний саналын томъёоллоор санал хураая. Санал хураалт.

Гишүүдийн 63.6% нь дэмжиж, саяын санал хураалт хүчингүй боллоо. Ингээд саяын санал хураалт хүчингүй болсон учраас дахин санал хураалт явуулъя. Санал хураалт.

Гишүүд ээ, анхааралтай байгаарай. Гишүүдийн 63.6% нь дэмжиж, санал дэмжигдлээ.

2. Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 3 дугаар зүйлийн дугаарыг “2” гэж өөрчлөх:

“1 дүгээр зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 5.1 дэх заалтын “Засгийн газар” гэснийг “Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, 5.7 дахь заалтын “тээвэрлэлтийн” гэснийг “тээвэрлэгчийн” гэж тус тус өөрчилсүгэй. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Гишүүдийн 63.6% нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Төмөр замын тээврийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрөөтэй 3 санал байна.

Санал 1. Төслийн 1 дүгээр зүйлийн “стандарт” гэснийг хасах, санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Гишүүдийн 54.5% нь дэмжиж, санал дэмжигдлээ.

2. Төслийн 4 дүгээр зүйлийг хасах, санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Гишүүдийн 63.6 хувь дэмжиж, санал дэмжигдлээ.

3. Төсөлд доор дурдсан агуулгатай зүйл нэмэх:

“4 дүгээр зүйл.Төмөр замын тээврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ болон хамт баталсан Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар төмөр замын зураг төсөл боловсруулах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ, суурь бүтцийн болон хөдлөх бүрэлдэхүүний эд ангийг үйлдвэрлэх, угсрах, засварлах үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр хэрэгжүүлэхээр

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

зохицуулсан зүйл, хэсэг, заалтыг Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу зөвшөөрлийг нэмэх, задлах, хуваах, салгах, түүний хамрах хүрээг өргөжүүлэх асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэсний дараа дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Гишүүдийн 54.5% нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналуудаар санал хураалт явуулж дууслаа.

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Ажлын хэсгийн ахлагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ уншиж танилцуулна.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал үүгээр өндөрлөж байна.

Ингээд хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүд та бүхэндээ баярлалаа. Ажлын хэсэгт баярлалаа.

Хуралдаан өндөрлөлөө.

Дууны бичлэгээс буулгасан:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ